


УЛААНБААТАР
БҮХ ТӨРЛИЙН НЭГ ЦЭГИЙ











Д.Туяа Д.Туул

ДАРХАД АМАН АЯЛГУУНЫ ТОВЧ ТОЛЬ

Улаанбаатар 2008

Дархад аман аялгууны товч толь

Зохиогч: Д.Туяа, Д.Туул
Хянан тохиолдуулсан: Шинжлэх Ухааны гавъяат
зүтгэлтэн, түүхийн ухааны доктор (Sh.D) О.Пүрэв,
Хэл шинжлэлийн доктор, профессор Ж.Санжаа, М.Базаррагчаа

Эх бэлтгэсэн: Ц. Мөнхнаран

Хэвлэлийн хуудас: 8хх

© Зохиогчийн эрх хуулиар хамгаалагдсан тул
зөвшөөрөлгүй хэвлэн олшруулахыг хориглооно.

“Улаанбаатар хэвлэл” ХХК-д хэвлэв.

Д.Туяа, Д.Туул

ДАРХАД АМАН АЯЛГУУНЫ ТОВЧ ТОЛЬ

Хянан тохиолдуулсан Шинжлэх Ухааны гавъяат зүтгэлтэн,
түүхийн ухааны доктор(Sh.D) О.Пүрэв,
хэл шинжлэлийн доктор, профессор
Ж.Санжаа, М.Базаррагчаа

Улаанбаатар 2008

Амгай үг

Монголын бичгийн хэлний эх ундарга нь уламжлалт сонгодог хэлээс гадна ярианы хэл, тэр дундаа монгол аман аялгуудын өвөрмөц үг хэллэг байдаг билээ.

Монголчуудын зан ахуй, соёл, түүхтэй холбогдол бүхий өвөрмөц үг хэллэг өтгөс өвгөдөөс уламжлан үлдэх нь даяаршихын хирээр улам саарч байгаа өнөө үед дархад аялгууны тухай бичсэн энэ ном монголчуудын утга соёлын далайд өчүүхэн ч боловч нэмэр болох нь дамжиггүй юм. Дархад аялгууны талаар 1927 онд Г.Д.Санжеевийн хийсэн судалгаанаас өөр доривтой бүтээл гараагүй ажээ. Юу гэвэл, дархад аялгуу нь түрэг монгол хэлний аль алины шинжийг агуулсан байж болох тул авианы төдийгүй түүний утга зүйг түүх, соёл, ялангуяа бөө шүтлэгтэй түүхчлэн судалбал нэн сонирхолтой болох нь гарцаагүй юм.

Жишээ нь дархад аялгууны "о"-лох нь эртний монгол хэлний гэргүүн үеэс хойш орох уруулын эгшгийг "о, у"-г ялгах, түүний хөгжил хувьслыг тайлбарлах нэг сэжим ч байж мэдэх юм.

Энэ мэтээр уг аялгууны сонин содон зүйлийг цаашид олон талаар гүнзгийрүүлэн судална байх гэж зохиогч нарт итгэж байна.

МУИС-ийн профессор М.Базаррагчаа

Д.Туяа, Д.Туул

ДАРХАД АМАН АЯЛГУУНЫ ТОВЧ ТОЛЬ

Хянан тохиолдуулсан Шинжлэх Ухааны гавъяат зүтгэлтэн, түүхийн ухааны доктор(Sh.D) О.Пүрэв, хэл шинжлэлийн доктор, профессор Ж.Санжаа, М.Базаррагчаа

Улаанбаатар 2008

Дархад аман аялгууны онцлог

Дархад ястан Хөвсгөл аймгийн Баянзүрх, Улаан–Уул, Ринчинлхүмбэ, Цагааннуур сумдад голлон, Алаг- Эрдэнэ, Арбулаг, Хатгал, Ханх зэрэг сумдад цөөн тоогоор нутаглахаас гадна Говь-Алтай аймгийн Халиун, Шарга сумдад их дархчуул, Чандмань суманд бага дархчуул, Ховд аймгийн Мянгад, Дөргөн, Эрдэнэ-Бүрэн сумдад хар дархад, Булган аймгийн Хутаг, Ховд аймгийн Дуут, Манхан, Дорнод аймгийн Булган сумдад жал дархад, Өвөр Монголд шар дархадууд нутаглаж байна.

Дархад аялгууг тусгайлан судалсан бүтээл цөөн бөгөөд тэдний гарал үүсэл, аман аялгууны онцлогийн талаар маргаантай зүйл нэлээд буй.

Орос буриадын монголч эрдэмтэн Г. Д. Санжеев "Дархатский говор и фольклор" ном, академич Д.Төмөртогоо "Дархадын аман аялгууны урт эгшиг, тэдгээрийн үүслийн тухай товч тэмдэглэл" өгүүлэл бичиж хэвлүүлсэн байна. Доктор С.Мөөмөө, Ю.Мөнх –Амгалан "Орчин цагийн монгол хэл аялгуу", Ж.Цолоо "БНМАУ-ын нутгийн аялгуу" бүтээлдээ дархад аман аялгууны талаар товч дурджээ. 1967 онд Э.Вандуй ахлагчтай шинжилгээний анги олон газраар судалгаа шинжилгээ хийсний нэгэнд нь Хөвсгөл аймгийн Ринчинлхүмбэ, Улаан-Уул сумдын нутгаар явж дархад аман аялгууны хэрэглэгдэхүүн цуглуулсан байна.

Угсаатны зүйч С.Бадамхатан "Дархад ястан" номдоо дархадуудын ёс заншил, түүх соёлын талаар дэлгэрэнгүй өгүүлсэн байна.

1962 онд академич Б.Ринченгийн удирдсан шинжилгээний анги дархад ардын олон сайхан дуу, үлгэрийг соронзон хальсанд бичиж авсан нь аман аялгуу судлаачдад үнэт хэрэглэгдэхүүн болох юм.

Судлаачдын дунд дархадын аман аялгууг чухам ямар аялгуунд хамааруулах вэ? гэдэг талаар санал зөрөөтэй байна. Тухайлбал, эрдэмтэн Г.Д.Санжеев "Дархаты, обитают на стыке трех разветвлений монгольского языкового мира: с юго-запада к дархатам прилегает многоговорное море ойратских племен, с юго-востока к ним примыкают многочисленные халхасцы, с северо-востока с ними имеют тесное экономическое, бытовое и языковое общение соверные буряты и наконец, они-дархаты-окружены островками, представителей тюркского языкового мира-урянхайцев(уйгуров как последние дархатами называются). Это обстоятельство, само собою разумеется, не могло не найти своего

выражения в языковых, явлениях дархатского говора"(Дархад нь гурван монгол хэлтний уулзварт орших ба баруун урд талаараа ойрдын олон аялгуутантай, зүүн урд талаараа халхчуултай хаяа залгах бөгөөд зүүн хойт талаараа буриадтай эдийн засаг, ахуй, хэлний талаар зузаан харьцаатай явж иржээ. Бас түрэг угсааны урианхай (тэднийг дархадууд уйгар хэмээн нэрлэдэг ажээ.) хэлтний хүрээлэлд амьдрах ажээ. Энэхүү нөхцөл байдал нь дархад аялгуунд нөлөөлөхгүй байхын аргагүй юм.) гэсэн бол академич Д.Төмөртогоо "Дархад аман аялгуу нь ойрд, халх, буриад аялгууны дундын байдалтай, С.Мөөмөө, Ю.Мөнх-Амгалан нар "Дархад аман аялгуу нь халх аман аялгууны нэгэн салбар аман аялгуу", Ж.Цолоо дархад аялгууг баруун халхын салбар аман аялгуунд, Я.П.Шишмарев дархад аялгууг хорь буриад хэлтэй ойр бөгөөд халимаг аялгууны шинжийг хадгалсан зүйл ч бий гэж дурджээ. Эрдэмтэн А.Д.Руднев дархадууд нь буриад аялгуунаас дөрвөд аялгуунд шилжиж байгаа завсрын аман аялгуутан, Г.Н.Потанин "Одоо үед монгол хэлээр ярьж буй дархад ястан урьд нь урианхай аялгуутай байсан бөгөөд турк хэлээр ярьдаг байсан бололтой. Учир нь тэдний бөө нар урианхай хэлээр бөөлдөг гэх мэтээр өөр өөр саналтай байна.

Бид өнөөгийн дархад амьд аялгууны авиазүй, хэлзүй, үгсийн сангийн онцлогийг ажиглавал, ойрд хотгойдын аялгуутай адил төстэй шинж нь давамгайлж буриад аялгуутай адил зүйл нь харьцангуй бага хувийг эзэлж байна. Жишээ нь:

Халх.ūšăg > Зах. ōšŏg > Дархад. ōšŏg

Халх. bodōd > Ойрд. bodād > Дархад. bodād

Дархадууд XIII-XYIII зууны эхэн үе хүртэл ойрд, хотгойдын захиргаанд байсан бөгөөд түүхийн энэ нөхцөл байдал нь тэдний хэл яриандаа ихээхэн нөлөөлсөн нь мэдээж хэрэг. 1207 онд Дархадын хязгаар Чингисийн ууган хүү Зүчийн өмч нутаг болсон авч Хутуга Бэхи, түүний хүү Иналчи нар Чингистэй худ ургийн холбоо тогтоосон учир ойрдын харьяанд хэвээрээ үлдэж, Зүчийн захиргааны улсын эрх мэдэлд явжээ.

XIY зууны эцэс XY зууны эхээр өрнөд, дорнод монголын феодлын дайн удтал үргэлжилж, Эсэн хааныг үхсэний дараа Төв Ази дахь Ойрдын ноёрхол унаж, дархадын хязгаар Батмөнх хааны отгон хүү Гэрсэнзийн төв нутаг болжээ. Үүнээс урьд дархадын нутаг, Алтайн олон овог аймаг (телеут, теленгут, тува) цөм ойрдын захиргаанд харьяалагдаж байжээ.

XYII зууны эхэн үед Хотгойд, Засагт хан аймагт харьяалагдаж,

нутаг нь Тува, баруун хойд Монголыг хамарсан ажээ.

Дээр өгүүлснийг нягтлан, одоогийн дархад аман аялгууы бодит баримтаас үзвэл, дархадын аман аялгууг ойрд, баруун халхын завсрын аман аялгуунд багтаан үзэх нь зүйтэй санагдаж байна.

Мөн дархадын аман аялгуу нь өөрийн гэсэн өвөрмөц онцлогтой хөгжсөнийг дараах шалтгаанаар тайлбарлаж болох мэт.

"Хөвсгөлийн дархад, Урианхайн хязгаар нь өмнө талаараа Манж Чин улсын харуул, хойд талаараа Орос, Манжийн 1727 онд тогтоосон хилийн торгон шугамын хооронд хавчуулагдаж соёлын талаар эх монголоосоо зааглагдсан байдалтайгаар 300 шахам жил болжээ.

Нэн ялангуяа Хөвсгөл нуурын баруун ба баруун өмнөдөд орших нутгийнхан ганцхан Бэлтэс харуулаар Халхын нутаг руу жилдээ ганц удаа нэвтрэхдээ төв суурин газруудаас хөндий "дархад зам" гэгчээр явж эдүгээгийн Эрдэнэт хотын орчимд байсан ноён хутагтын хүрээгээр дайран хийдийн гортиг орох, гарахдаа буу тавиулж, бүх айлын өрх татуулж, хүн бүрийг гэр, дуган сүмд нь суулгаж байгаад өнгөрч Их Хүрээнд ирээд буудаг газар нь ч тусгай байжээ. Энэ нь тус хязгаарын бөөгийн шашныг халхчуудын дунд хүчтэй дэлгэрсэн бурхны шашны нөлөөнөөс тусгаарлан, өөрөөр хэлбэл харын бөөгийн шашны нөлөөлөл халхчуудын дунд дахин дэлгэрэхээс болгоомжилсон хэрэг байжээ." гэж доктор О.Пүрэв "Хар дархадын хураангуй түүхээс" номдоо бичжээ.

Энэ бүхнээс шалтгаалан дархад аман аялгуу нь дунд үеийн монгол хэлний онцлогийг хадгалж үлдсэн ба өөрийн гэсэн өвөрмөц онцлогтой аялгуу болон хөгжсөн нь тодорхой байна.

Дархад аман аялгууны авиа зүйн онцлог

1. Дархад аялгууны үгийн эхэнд орсон "э, и" хоёрыг тодорхой ялгадаггүй, ихэвчлэн зөөлөн гийгүүлэгчийн нөлөөгөөр "э, и" авиа сэлгэх ба ихэвчлэн "и" эгшгээр хэлж байна. Жишээ нь: бэлчээр-билчээр, элч-илч, нэмгэн-нимгэн, эмжээр-имжээр

2. Зарим үгийн эхний "о-у" авиаг хутгадаг. чохом-чухам, хошоо-хушоо, шовоо шувоо

3. Нэгдүгээр үеийн урт "ий"-тэй байсан үгийн "ий" нь хоёрдугаар үеийнхээ эр эгшигтэй ухран ижилссэн. Жишээ нь: чаараг-чийрэг, шаадам-шийдэм, шаар-шийр

4. Эр үгийн нэгдүгээр үеийн "и" бүрэн нугарал болоогүй. Жишээ нь: бислаг-бяслаг гэх мэт. Энэчлэн орчин цагийн бичиг зохиолын

хэлний үгийн эхэнд тохиолддог "я"-г зарим үед "и"-гээр хэлдэг. Жишээ нь: илжи-ялз, илжрэх-ялзрах,

5. Гэвч энэ аялгуунд монгол бичгийн хэлний нэгдүгээр үеийн "и" эгшиг нэлээд олон үгэнд нугараагүй хэвээрээ байна. Жишээ нь: чираэ-царай, чираэдах-уурлах, минги-мянга, бироо-бяруу, шинаа-шанаа, химд-хямд

6. Утга зохиолын хэлний "эй"-ийн хос эгшиг нь дархад аман аялгуунд бүх тохиолдолд урт "ээ" эгшгээр; "ай"-ийн хос нь үгийн нэгдүгээр үедээ ихэд урагшилсан ǟ, нэгдүгээр үеэс хойш урт эгшиг ē, "ой"-гийн хос нь нэгдүгээр үедээ "оэ"-ийн хос, урт оо, өө, тагнайшсан гийгүүлэгчийн орчим зарим үгэнд ихэд урагшилсан ǟ, нэгдүгээр үеэс хойш урт "ээ", зарим үгэнд ихэд урагшилсан ǟ, "уй"-гийн хос нь үгийн нэгдүгээр үед "оэ"-ийн хос, урт "уу, үү", нэгдүгээр үеэс хойш урт "ээ, ио"; "үй"-гийн хос нь нэгдүгээр үед урт үү, "өө", нэгдүгээр үеэс хойш "ээ" болон хэлэгдэнэ. Жишээ нь:

Утга зохиолын хэл	Дархад аман аялгуу
бэйл	бээл
эмэгтэй	эмэгтээ
айл	ǟl
амгай	амгээ
бойжуул	боожоол
бойтог	боэтаг
Чой	Чөө
сойз	šǟdz
ёлтой	ёлтээ
шолхой	шолхǟ
уйлах	уулих("л" үсгээ тагнайшуулдаг)
гуйвуулга	гоэвоолга
буйл	бүүл
бугуй	бугээ
бугуйлд	бугиольд
хүйс	хөөс
гүйх	гүүх
үгүй	үгээ

7. Уруулын ба хэлний үзүүрийн гийгүүлэгчийн өмнө уруулын хамжих "б" авиаг тодорхой хэлнэ. Жишээ нь: аббал-авбал, яббал-явбал, абдар- авдар, хабтас-хавтас, абцаа- авцаа, тобчи-товч, набчи- навч

8. Үгийн дунд орсон “ж,ч,ш“ гийгүүлэгчийн дараах “и“ эгшиг нь нэгдүгээр үеийнхээ эгшигтэй дэвшин ижилсдэг. Жишээ нь: ажал, ашаг, учар, очор, мөчөр, хөгшөн, хоршох, оршох гэх мэт

9. Үгийн дунд дэвсгэрлэж ордог “д, с”-ийн дараа “г” биш “х” хэлдэг.Жишээ нь: бэлэдхэл, батадхал, урасхал, дурасхал

10. Дархадын аман аялгуунд “ц-ч”, “ж-з” авиа сэлгэдэг. Жишээ нь: гачигдал- гацагдал цоож-цооз

11. Авианы хөгжлийн аясаар халхын аялгуунд “ц” болсон авиаг энэ аялгуунд заримдаа дунд үеийн монгол хэлний дуудлагаар “ч”-ээр хэлдэг. Жишээ нь: чирае-царай, бичигэн-бяцхан, охин

12. Эртний монгол хэлэнд “д-з, ш-с” авиа хоорондоо сэлгэдэг байжээ. Дархадын аман аялгуунд мөн энэ үзэгдэл байна. гадаа-газаа, сөни-шөнө, сойз- шайз, нулгаах-зулгаах, нанчих-занчих

13. Зарим үгийн “т” авиаг “ч, ц, з”-гээр сольж хэлдэг. Жишээ нь: Хубтас-хувцасz хабтас-хабцас, хатавч- хазавчи,

14. Зарим үгийн “б, в” авиаг “м” авиагаар сольж хэлнэ. Жишээ нь: бохь-мохь, зэвсэг-зэмсэг Заримдаа “м”-тэй үгийг “б”-гээр, мөн “в”-тэй үгийг “г”-гээр сольж хэлдэг. Жишээ нь: шөрмөс-шөрвөс, дэвтэр-дэгтэр

15. Утга зохиолын хэлний “н” авиаг “м”-ээр сольж хэлэх нь бий. Жишээ нь: унших- умших, унда-умда Мөн “м” авиаг “н” авиагаар сольж хэлэх нь бий. өмч- өнч, ханцуй-хамцоо

16. Үгийн дунд хэлний угийн “н”-ийн дараа шүргэх “х” орвол “к” шиг хамжиж дуудагдана. Жишээ нь: төнхөр -төнкөр, ханхар-ханкар, шанх-шанк

17. Гийгүүлэгч авиа “р, л, м, г, ш” нь хоорондоо байр сольж тонгорох тохиодол бий. Жишээ нь: догшин-дошгон, хярам-хямар, алчуур-арчоол,

18. Халхын аялгуунд үгийн эхний үед аль хэдийнээ гээгдсэн гийгүүлэгч дархадын аман аялгуунд зарим үгэнд хэвээрээ байна. Жишээ нь: олгой-голгой

19. Зарим үгийн эхэн дунд адгаас авиа сугарсан.Жишээ нь: нээрээ-үнэхээр, салдарга- сагалдарга, өмхий-хөмхий, отлох-оглох

20. Дунд үеийн монгол хэлний дуудлага бичлэгийг хадгалж үлдсэн үг ч бас байна. Жишээ нь:цаас-цаарас, арьс-арас, илүү-үлөө, шийс-шээс, сөнө-шөнө, хурууд-хурд,

21. Дархад аман аялгуунд бичиг зохиолын хэлний үгэнд авиа нэмж оруулан хэлэх тохиолдол байна. Жишээ нь: өчигдөр-өцгэлдээр, гогдох-гонгадах, шалдан-шалдган

22. Дархадын аман аялгууны урт эгшгийн бүрэлдэхүүнийг эрдэмтэн судлаачид хэрхэн тогтоосныг авч үзье. Эрдэмтэн Г.Д.Санжеев ā, ă̄, ē, ī, ō, ŏ̄, ū, ŭ̄ гэсэн , урт эгшиг, академич Д.Төмөртогоо ā, ă̄, ē, ī, ō, ŏ̄, ū, ŭ̄ буюу ī̆-г нэмээд 9 урт эгшиг, доктор С.Мөөмөө, Ю.Мөнх-Амгалан нар “Халх аялгуунд байхгүй а, і гэсэн урт эгшиг дархад аялгуунд байна” гээд 9 урт эгшиг гэх мэтээр урт эгшгийн бүрэлдэхүүнийг тогтоожээ. Г.Д.Санжеев хуруу, суу, асуу, уул, үүле, хүүхэд, зүүдэн, уруул гэх мэт урт эгшиг уу-тай жишээ татсаныг одоогийн аман аялгуундаа хуроо, соо, асоо, оол, өөл, хөөхэд, зөөд, урал гэх мэтээр урт оо, өө, богино а эгшгээр хэлж байна.

Тэгвэл дархад аман аялгууг судлан үзэхэд халхын аман аялгууны урт эгшиг “уу, үү” үүссэн байранд дархад аман аялгуунд урт “оо, өө” эгшиг үүсч, харин үгийн нэгдүгээр үеэс хойш урт “оо, өө” эгшиг үүссэн байранд урт “аа, ээ” үүссэн нь сонин байна. Харин дархад аман аялгуунд урт “уу, үү” эгшигтэй үг маш цөөхөн тохиолдож байгаа ба энэ нь хос эгшиг “уй, үй” үүсэх байранд үгийн утга ялгах үүднээс урт “уу, үү” болсон ажээ. Жишээлбэл: “үүл” гэхийг дархад аман аялгуунд “өөл” гэж урт “өө” эгшгээр дуудаад харин “үйл” гэхийг ялган “үүл оёх” гэх мэтээр хэлж байна.

Халхын аялгуунд урт “уу, үү”-гээр хэлдэг үгийн заримыг бүр богино эгшгээр хэлж байгаа тохиолдол ч байна. Жишээ нь: уруул-урал, гүүр-гүр, хурууд-хурд гэх мэт.

Дархад аман аялгуунд урт” уу, үү” бараг байхгүй (бидний түүж хавсаргасан жишээнд урт “уу, үү” эгшигтэй үг ердөө 20 орчим) байгаа нь дархад аман аялгуу нь о-оорхог, ө-өөрхөг аялгуутан юм. Өөрөөр хэлбэл, уруулаар зохицон ижилсдэг дунд үеийн монгол хэлний авианы хуулийн онцлогийг хадгалсаар ирснээс шалтгаалжээ гэж үзэж болох ба уруулын уйтан эгшиг нь уруулын, дунд зайтай хэлэгддэг эгшиг болон давамгайлж хөгжсөн байдал ажиглагдана.

Mo.nagur>na’or > no’or >Дархад.nōr

Mo.egule >e’ule> ȯ’ule > ȯ’ȯle >Дархад.ō̆l

Сугарсан гийгүүлэгчийн өмнөх богино эгшиг нь уруулын байлаа ч гэсэн дараах үеийнхээ уруулын бус урт эгшигтээ татагдан ухарч ижилсдэг байжээ. Жишээ нь: Mo. doluγan> dolu’an> dolo’an> dola’an> dolān болсон нь дархадын аман аялгуунд урт эгшиг үүссэн авианы хууль ёс бөгөөд ойрдын аялгууныхтай адил юм. Дархад аялгуунд урт ī (ы) байхгүй, учир нь урт ī̆(ы)- ийн үүргийг ихэд урагшилсан урт

() гүйцэтгэдэг ба бараг е авиа шиг сонсогдоно. Иймэрхүү үзэгдэл ойрд, хотгойдын аман аялгуунд ч нэгэн адил ажиглагддаг бөгөөд хотгойдын аман аялгуунд харъяалахын тийн ялгалын nä,nē нөхцөл байдаг гэсэн нь чухамдаа энэ ихэд урагшилсан а: эгшигтэй тохирч байна. Жишээлбэл: toγ-a-nē (e) taγ гэх мэт.

Дархад аман аялгууны 6 урт эгшиг тус бүрийн хувилбарыг гаргаж, гарлыг нь тэргүүн ба тэргүүн ба тэргүүн бус үеийн гэж хоёр ялган, халх аялгуутай харьцуулан тодорхойлсныг дараах хүснэгтээс уншина уу.

Дархадын аман аялгууны урт эгшгийн хувилбар, гарлыг халхын аман аялгуутай харьцуулсан нь

Урт эгшиг фонем

Халхын аман аялгуунд	Дархадын аман аялгуунд
[ā] < ā Mo. baγatur > X. bātăr; ą̄ Mo. jiγaqan > X.džą̄xăn	[ā] < ā Mo. baγatur > X. bātar > Дарх. bātăr; ą̄ Mo. jiγaqan > X.džą̄xăn > Дарх. džą̄xăn
Гарал	
Mo. aγa > Mo. baγatur > X. bātăr Mo. iγa> Mo. jiγaqan > X.džą̄xăn	Mo. aγa > X.ā > Дарх. ā Энэ нь халхын аман аялгуутай адил өмнө нь а, і эгшиг орж байсан хамжих γ-ийн дараа орсон а-аас урт эгшиг ā үүсчээ.
Үгийн тэргүүн үеэс хойш	
1. Mo. aγa>X.ā Үгийн нэгдүгээр үед нь a, u орж байсан aγa> ā үүсчээ. Mo. alaγaci > X.alātš Mo. jujaγan > X.dzudzān Mo. bayičaγaγči > X.bāētsāxtšʌ 2.Mo. a> X.ā үгийн нэгдүгээр үед нь a, ayi, u, uyi орж байсан үгийн дунд буюу эцэст орсон богино а-аас ā үүсчээ. Mo. absarqan > X.awsārxan Mo. aliba > X.al'wā	Дархадын аман аялгуунд aγa>ā, a>ā, uγa>ā, iγa>ā үүсэн нь адилхан байна. Харин халхын аман аялгууныхаас ялгаатай нь ō үүсэх байранд дархад аман аялгуунд ā үүсчээ.Тухайлбал: I. Mo aγa> X.ō~ Дарх.ā үүсчээ. Үгийн нэгдүгээр үед нь o, oyi орж байсан aγa>ā үүсчээ. Mo. bolūlčaγ-a> X. bolōltsō ~ Дарх. bolōltsā Mo. oyiralčaγ-a> X. ǭrōltsō ~ Дарх. ǭrāltsā

3. Mo. aγa >X.ā Үгийн нэгдүгээр үед нь a, u, ayi орж байсан үгийн дунд буюу эцэст орсон > ā үүсчээ. Mo.alalduγan>X.alāldān Mo.bayilduγan>X.bą̄ēldān 4. Mo iya >X.ā Үгийн нэгдүгээр үед нь a,u орж байсан үгийн дунд буюу эцэст орсон iya >ā үүсээ Mo.aljiyal > X.al'džāl Mo.ukiya > X.uγā	II. Mo.uγa> X. ō> ~ Дарх. ā Нэгдүгээр үед нь o, i орж байсан uγa>ā үүсчээ. Mo.boruγaqu> X.borγōx ~ Дарх. borγāx Mo.jiruγ-a> X. džorō ~ Дарх. džorā III. Mo.uγa> X. ō> ~ Дарх. ā Нэгдүгээр үед нь o, i орж байсан uγu>ā үүсчээ. Mo.moquγu> X.moxō ~ Дарх. moxā Mo.jiluγ-a> X. džolō ~ Дарх. džolā IY. Mo.iya, u > X. ō> ~ Дарх. ā Нэгдүгээр үед нь o орж байсан uγu>ā үүсчээ. Mo. dobjiya > X.dowdžō ~ Дарх. dobdžā Mo.bolγumji> X. bolγōmdžʌ ~ Дарх. džolγāmdžʌ

Урт ē эгшиг фонем

Халхын аман аялгуунд	Дархадын аман аялгуунд
[ē] < ē Mo. egemüg > X. ēmĕg; ę̄ Mo. sigesü > X. šę̄s	[ē] < ē Mo egemüg > X.ēmĕg > Дарх. ēmĕg; ę̄ Mo sigesü > X. šę̄s > Дарх. šīs
Гарал	
Mo. ege >ē Mo. egemüg > X. ēmĕg Mo. ige > Mo. jigele > X.dzēl	Mo. ege > ē. Mo. egemüg > X. ēmĕg Дарх. ēmĕg Mo. ige > Mo. jigele > X.dzēl Дарх. dzēl
Үгийн тэргүүн үеэс хойш	
1. Mo. ege>X.ē Үгийн нэгдүгээр үед нь e, i, ü орж байсан ege> ē үүсчэ ·. Mo. medege > X.medē Mo. ibegel > X.iwēl Mo. gübege > X.güwē 2.Mo iye > X.ē Үгийн нэгдүгээр үед нь e, i, ü, орж байсан үгийн дунд буюу адагт орсон iye-гээс ē үүсчээ.	Дархадын аман аялгуунд Mo. ege>X. ē ~ Дарх. ē Mo. iye>X. ē ~ Дарх. ē Mo. üge>X. ē ~ Дарх. ē үүссэн нь адилхан байна. Харин халхын аман аялгууныхаас ялгаатай нь ō үүсэх байранд дархад аман аялгуунд ē үүсчээ. Тухайлбал:

Mo belgesiyekü > X. belĕgšĕx Mo jisiye > X. džĭšĕ Mo üriy -e > X. ürĕ 3. Mo ige >X.ĕ Үгийн нэгдүгээр үед нь e, i орж байсан үгийн дунд буюу эцэст орсон ige >ĕ үүсчээ. Mo.belčiger>X.beltšĕr Mo.bičigeči>X.bitšĕtš 4. Mo e >X.ĕ Үгийн нэгдүгээр үед нь e, ü орж байсан үгийн дунд буюу эцэст орсон e >ĕ үүсчээ Mo.gege > X.gegĕ 5. Mo üge >X.ĕ Үгийн нэгдүгээр үед нь ü орж байсан үгийн дунд буюу эцэст орсон üge >ĕ үүсчээ Mo.bütügegdekün > X. bütĕgdĕxŭn	I. Mo üge > X. ŏ~ Дарх.ĕ үүсчээ. Үгийн нэгдүгээр үед нь ö, i, e орж байсан üge >ĕ үүсчээ. Mo.mörügedül > X.mȯrŏdŏl ~ Дарх. mȯrĕdĕl Mo.irüger> X. jȯrŏl ~ Дарх. jȯrĕl II. Mo. ü, ige, e, iye, ege X. ŏ> ~ Дарх. ĕ. Үгийн нэгдүгээр үед нь ö орж байсан үгийн дунд буюу адагт орсон ü, ige, e iye, ege >ĕ үүсчээ. Mo.böglege > X.bȯglŏ ~ Дарх. bȯglĕ Mo.jöbšiyerel > X. dzȯbšŏrŏl ~ Дарх. dzȯbšĕrĕl Mo.önjigekü > X. ȯndžŏx ~ Дарх. ȯndžĕx Mo.önüdür > X. ȯnŏdŏr ~ Дарх.ȯnĕdĕr Mo.sögerge > X. sŏrgŏ ~ Дарх. sŏrgĕ

Урт ĭ эгшиг фонем

Халхын аман аялгуунд	Дархадын аман аялгуунд
[ĭ]- ĭ Mo. čigig > X. tšĭg	[ĭ]- ĭ Mo čigig > X. tšĭg > Дарх. tšĭg
Гарал	
Mo. igi >ĭ Mo. čigig > X. tšĭg Mo. eyi >ĭ Mo. keyiskü > X. xĭsex	Mo. igi >ĭ Mo. čigig > X. tšĭg> Дарх. tšĭg Mo. eyi >ĭ Mo. keyiskü > X.xĭsĕx > Дарх.xĭsĕx Энэ нь халхын аман аялгуутай адил өмнө нь i, e эгшиг орж байсан g, y-ийн дараа орсон i-ээс урт эгшиг ĭ үүсчээ.
Үгийн тэргүүн үеэс хойш	
1. Mo.eyi>X.ĭ Үгийн нэгдүгээр үед нь i, e, ü, ö орж байсан eyi> ĭ үүсчээ. Mo.ilerkeyilkü > X. ilĕrxĭlĕx Mo.bögedeyikü > X.bŏdĭx Mo.degleyi > X.deglĭ 2.Mo üyi > X.ĭ Үгийн нэгдүгээр үед нь ö, ü орж байсан үгийн üyi -гээс ĭ үүсчээ. Mo ömüyikü > X. ömĭx	Дархадын аман аялгуунд арай хойшлуулж хэлдэг учир ĭ-г ĕ хэлж байгаа юм шиг сонсогддог. Гарал үүсэл нь халхын аялгууны нэгдүгээр үеэс хойш урт эгшиг ĭ үүссэнтэй ижилхэн. Mo tüntüyikü > X.tüntĭx> Дарх.tüntĕx

Mo tüntüyikü > X.tüntĭx 3. Mo i >X.ĭ Үгийн нэгдүгээр үед нь e, i, a, o орж байсан i >ĭ үүсчээ. Mo.erlije>X.erlĭdz Mo.narin>X.narĭn Mo.bokiskikü>X.boxĭsxĭx 4. Mo iy >X.ĭ Mo.soljiyiqu > X.soldžĭx Mo.birjiyikü > X.birdžĭx	

Урт ŏ эгшиг фонем

Халхын аман аялгуунд	Дархадын аман аялгуунд
[ŏ] < ŏ Mo. ögedes > X. ŏdŏs; ŏ Mo. ögesi > X. ŏš	[ŏ] < ŏ Mo. ögedesü > X. ŏdŏs > Дарх. ŏdŏs; ŏ Mo. ögesi > X. ŏš> Дарх. ŏš
Гарал	
Mo. öge >ŏ Mo. čögeken > X. tsŏxŏn Mo. ögü >ŏ Mo čögürüm > X. tsŏrŏm	Mo. öge >ŏ Mo. čögeken > X. tsŏxŏn > Дарх. tsŏxŏn Mo. ögü >ŏ Mo čögürüm > X. tsŏrŏm > Дарх. tsŏrŏm Энэ нь халхын аман аялгуутай ижил байна. Харин 1.Mo. ùyi > X. ùi > Дарх. ŏ Mo. xùyiten > X. xùitĕŋ > Дарх.xŏtĕŋ Mo. sùyixe > X. sùix > Дарх.sŏx 2.Mo. oi > X.oi > Дарх. ŏ Mo. tšoi > X. tšoi > Дарх. tšŏ
Үгийн тэргүүн үеэс хойш	
1. Mo.üge>X.ŏ Үгийн нэгдүгээр үед нь i, e, ö орж байсан үгийн дунд буюу адагт орсон üge> ŏ үүсчээ. Mo.mörügedül > X.mȯrŏdŏl Mo.irüger > X.jȯrŏl 2.Mo ü, ige, e, iye, ege > X.ŏ Үгийн нэгдүгээр үед нь ö орж байсан үгийн дунд буюу эцэст орсон ü, ige, e, iye, ege > X.ŏ үүсчээ.	Халхын аман аялгуунд урт эгшиг ŭ үүсэх байранд дархадын аман аялгуунд ŏ үүссэн байна. 1.Mo.egü>X.ŭ> Дарх.ŏ Үгийн нэгдүгээр үед нь ö, ü, e орж байсан үгийн дунд буюу адагт орсон egü>ŏ үүсчээ. Mo. bitegü > X.bitŭ ~Дарх.bùtŏ Mo.böglegü > X. bȯglŭ ~ Дарх.bȯglŏ

Mo böglege > X. bòglō Mo jöbsiyerel > X. dzówšōrǒl Mo.önjigekü>X. öndžǒx Mo.önüdür>X. ónǒdǒr Mo.sögerege>X.sǒrgǒ	Mo. büselegür > X.bùslǔr ~ Дарх. bùslǒr Mo.belkegüsü > X. belxǔs ~Дарх. belxǒs 2.Үгийн нэгдүгээр үед нь ö, ü, e орж байсан үгийн дунд буюу адагт орсон igü>ō үүсчээ. Mo. biškigür > X.bišgǔr ~ Дарх.bišgǒr Mo.jörigüü > X. dzòrū ~ Дарх. dzòrō Mo. gübigür > X.gùwǔr ~ Дарх.gùwǒr Mo.ebčigü > X. ewtšū ~Дарх. ewtšō 3.Mo.ügü>X.ǔ ~Дарх.ō Үгийн нэгдүгээр үед нь ü, e орж байсан үгийн ügü>ō үүсчээ. Mo. büdügübči > X.büdǔwtšə ~ Дарх. büdǒwtšə Mo.debigür > X. dewǔr ~Дарх. dewǒr 4.Mo.ü > X.ǔ ~Дарх.ō Нэгдүгээр үед нь ü,e,i орж байсан ü>ō үүсчээ. Mo.jigür > X. džigǔr ~Дарх. džigǒr Mo. biškigür > X.bišgǔr ~Дарх. bišgǒr Mo.sedkül > X.sedgǔl ~Дарх. sedxǒl Mo.ügülekü > X.ùgǔlěx ~Дарх.ùgǒlěx 5.Mo.eü > X.ǔ ~Дарх.ō Үгийн нэгдүгээр үед нь i, ö, ü, e орж байсан eü >ō үүсчээ. Mo.ideür > X.idǔr ~Дарх. idǒr Mo. sörgeü> X.sörgǔ ~Дарх.sörgō Mo. jüdereü> X.dzùdrǔ ~Дарх. dzùdrō Mo. kerseü> X.xersǔ ~Дарх. xersō

Урт эгшиг ō фонем

Халхын аман аялгуунд	Дархадын аман аялгуунд
[ō] < ō Mo. qoγusun > X. xōsōn ǭ Mo. šoulaqu > X. šǭlōx	[ō] < ō Mo. qoγusun > X. xōsōn Дарх. xōsōn ǭ Mo. šoulaqu > X. šǭlōx> Дарх. šǭlōx
Гарал	
Mo. oγa >ō Mo. toγ-a > X. tō Mo. oγu >ō Mo.oγusur > X.ōsōr	Mo. oγa >ō Mo. toγ-a > X. tō ~ Дарх.tō Mo. oγu >ō Mo.oγusur > X.ōsōr ~ Дарх.ōsōr Mo. aγu >ō Mo. aγula > X. ūl ~ Дарх.ōl Mo. uγu >ō Mo.juγuqu > X.dzūx ~ Дарх.dzōx Mo. iγu >ō Mo. jiγuraqu > X. dzūrāx ~ Дарх.dzōrāx Mo. oyi > X. oi > Дарх. ō Mo. boyijiγul > X. bǭĭdžūl ~ Дарх.bǭdžǭl
Үгийн тэргүүн үеэс хойш	
1. Mo.aγa>X.ō Үгийн нэгдүгээр үед нь o, oyi орж байсан үгийн дунд буюу адагт орсон aγa> ō үүсчээ. Mo.bolulčaγ-a > X.bolōltsō Mo.oyiralčaγ-a > X.ōelōltsō 2.Mo.uγa > X.ō Үгийн нэгдүгээр үед нь o, i орж байсан үгийн дунд буюу эцэст орсон uγa >ō үүсчээ. Mo boruγaqu > X. boryōx Mo jiruγ-a > X. džorō 3.Үгийн нэгдүгээр үед нь o, i орж байс ан uγu>ō үүсчээ. Mo. ɲoquγu>X.ɲoxō Mo.jiluγu >X.džolō 4.Mo.iγa>X.ō Mo.u>X.ō Үгийн нэгдүгээр үед нь орж байсан үгийн дунд буюу эцэст орсон iγa, u>ō үүсчээ.	Халхын аман аялгууны урт эгшиг u үүсэх байранд дархадын аман аялгуунд ō үүсдэг 1. Mo.aγu>X.ū ~ Дарх.ō Үгийн нэгдүгээр үед нь ayi, a, i, o, u орж байсан үгийн дунд буюу адагт орсон aγa> ō үүсчээ. Mo.dumdaγur > X.dundūr ~ Дарх. dundōr Mo.angnaγur > X.aγnūr ~ Дарх. aγnōr Mo.biraγu > X.birū ~ Дарх.birō Mo.γouldaγu > X.γoldū ~Дарх.γoldō 2.Mo.iγa > X.ū ~ Дарх.ō Үгийн нэгдүгээр үед нь a, ayi, u, o орж байсан үгийн дунд буюу эцэст орсон iγu >ō үүсчээ. Mo.oburjiγu >X. owǒrdžū ~ Дарх.owǒrdžō

Mo.dobjiya >X.dowdžō Mo.bolγumji >X.bolγōmdž	Mo adališiγulaqu > X.adilšǭlāx ~ Дарх. adilšǭlāx Mo.bāērsiγul >X. bāēršǭl ~ Дарх. bāēršǭl Mo.γubčiγur >X. γuwtšǭr ~ Дарх. γuwtšǭr 3. Mo.uγu > X.ū ~ Дарх.ō Үгийн нэгдүгээр үед нь a, u, o, i орж байсан uγu>ō үүсчээ. Mo.aduγu>X.adū ~ Дарх. adō Mo.niruγu >X.nurū ~ Дарх.nurō Mo.dotuγur >X.dotūr ~ Дарх.dotōr Mo.nuquγur >X.nuxūr ~ Дарх.nuxōr 4.Mo. au>X.ū ~ Дарх.ō Үгийн нэгдүгээр үед нь i, a орж байсан au>ō үүсчээ. Mo.bildauči >X.b'ạldūtš ~ Дарх. b'ạldōtš Mo.nalau >X.nalū ~ Дарх.nalō 5.Mo. u>X.ū ~ Дарх.ō Үгийн нэгдүгээр үед нь u, a, o орж байсан u>ō үүсчээ. Mo.naγaγur >X.nāγūr ~ Дарх. nāγōr Mo.bulduruu >X.buldārū ~ Дарх. buldārō

Урт ū фонем

Дархад аман аялгуунд урт эгшиг ū бараг байхгүй. Гэхдээ бидэнд ажиглагдсан 7 үгийн ū эгшгийн гарлыг тодорхойлъё. Зарим дархад хүмүүс энэ үгийг урт ō-гоор дуудна гэж хэлж байв.

Дархад аман аялгуунд	
[uyi]-ū	Mo.uyilaγ-a >X.ūilā ~ Дарх. ūlia (ихэвчлэн орилах гэж ярьдаг) Mo.uyidxu >X.ūidax ~ Дарх. ūdix Mo.uyilaγan >X.ūilāŋ ~ Дарх. ūliāŋ Mo.guyiramtši >X.gūirāmtšǐ ~ Дарх. gūrimtšǐ Mo.guyirataxu > Дарх. gūrtāx
[uyu]-ū	Mo.guyulγ-a >X.gūiγ-a ~ Дарх. gūlig Mo.guyulgatšiŋ >X.gūilgātšiŋ ~ Дарх. gūligtšiŋ

Урт ū фонем

Дархад аман аялгуунд урт эгшиг ū бараг байхгүй. Гэхдээ хос эгшгийн байранд үүссэн цөөхөн урт ū эгшигтэй үг ажиглагдсан тул ū эгшгийн гарлыг тодорхойлъё.

[ùyù]-ū	Mo.gùyùdel >X.gūidēl ~ Дарх. gǔdēl Mo.gùyùldexù >X.gūildēx ~ Дарх. gǔldēx Mo.gùyùxù >X.gūix ~ Дарх. gǔx
[ùyù]-ū	Mo.gùyixen >X.gūixēŋ ~ Дарх. gǔxēŋ Mo.gùyičēxù >X.gūitsēx ~ Дарх. gǔtsēx
[uyi]-ū	Mo.buyila >X.bǭil ~ Дарх. bǔl

Бүтээвэр зүйн онцлог

1. Биеийн төлөөний үгээ үйл үгийнхээ ард хураангуйлан шууд залган хэлдэг. Жишээ нь: явнав-Би явъя, явнооч-Чи яв, аваат- Та ав, Явхав -Би явна

2. Биеэр төгсгөх "-ктээ" нөхцөл нь 2-р биеийн хүндэтгэх хэлбэр, татгалзах боломжгүй, тушаан гүйцэтгэх утгатай. Жишээ нь: Ирэктээ- Та ирэгтүн. Ирээрэктээ- Та ирээрэй. Энэ нь хоёрдугаар биеийн зөвлөн захирах нөхцөл (-аарай, -ээрэй) дээр мөн биеийн хүндэтгэн захирах нөхцөлийг залгаж бүтсэн ба хотгойд аялгуунд ч ингэж хэлнэ.

3. Биеэр төгсгөх "-аат,-ээт(ā̆t)" гэсэн нөхцөл бий. Мөн гуйж хүсэмжилсэн утга давхар илтгэнэ. Жишээ нь: Та тигээт- Та тэг.

4. Биеэр төгсгөхийн сануулан захирах нөхцөл нь -оозээ, -өөзээ гэсэн хувилбартай. Жишээ нь: явоозээ-явуузай, хэлөөзээ-хэлүүзээ

5. Биеэр төгсгөхийн шаардан захирах нөхцөлийг зөвхөн –аач, -ээч(ā̆tš) гэсэн хувилбараар хэлнэ. Жишээ нь өгээч, бодаач гэх мэт. Мөн энэ нөхцөлийг –даа, -дээ хувилбар гэсэн сул баймжит бүтээвэр орлож болно. Жишээ нь: өгдээ- өгөөч, боддаа-бодаач. Энэ бүтээвэрийн ард асуух гуйх утгатай –жоо гэсэн өвөрмөц баймж бүтээвэр залгаж хэлдэг. Надад өгдээ жоо- Надад өгөөч дээ.

6. Биеэр төгсгөхийн ерөөн хүсэхийн -аасай4 нөхцөл нь зөвхөн -аасээ, -ээсээ(ā̆sē) гэсэн хувилбартай. Жишээ нь: бодаасээ-бодоосой, өгээсээ-өгөөсэй

7. Ерөнхийлөн асуух баймжит бүтээврийг "уу, юу"-г "ёо" гэж хэлдэг. Жишээ нь: Маанар явъя ёо – Бид явах уу? Ёо авааВич?- Чи юу аваа вэ?

8. Асуух утгатай бит, бич гэсэн өвөрмөц хэлбэр бий. Энэ нь өнгөрөн төгссөн цагийн нөхцөл ба хоёрдугаар биеийн төлөөний үгээс үүсчээ. Жишээ нь: Ёо аваавич?- Чи юу аваа вэ? Та хэдэн багачоолтээ бит?- Та хэдэн хүүхэдтэй вэ?

9. Үйлийн далимдах тийн ялгалын –нгуут, -нгүүт нөхцөлийг –нгоот, -нгөөт гэж хэлдэг. Жишээ нь: ирэнгөөт-ирэнгүүт, оолзангоот-уулзангуут

10. Үйлийн үргэлжлэх тийн ялгалын -саар[4] нөхцөлийг зөвхөн –саар, -сээр(sa̋r) нөхцөлөөр хэлдэг. Жишээ нь: бодсаар-бодсоор, өгсээр- өгсөөр

11. Үйлийн урьдчилах тийн ялгалын –аад[4] нөхцөлийг –аад, ээд (a̋d) нөхцөлөөр хэлдэг. Жишээ нь:бодаад-бодоод, нөхээд-нөхөөд гэх мэт

12. Энэ аялгуунд баймж бүтээвэр үг нь үйл өгүүлэхүүнтэйгээ нийлж хэлэгдэнэ. Жишээ нь: Байгаа юм л даа-байгаамалдаа. Та сав ороо хийлөөт.-Та сав руу хийсэн үү? (Та сав руу хийл(ээ) үү,та)

13. Үйлийн чиглэхийн тийн ялгалын уруу, үрүү(руу, рүү) нөхцөлийг ороо, өрөө гэж хэлнэ. Сав ороо- сав руу, хөл өрөө- хөл рүү, Чи адоороогаа явнооч.-Чи адуу руугаа явах уу?

14. Та нар, тэд, бид гэсэн биеийн төлөөний үгийг тааноос, маанар, мааноос, тэднээс гэж ярьдаг.

15. Харьяалахын тийн ялгалын нөхцөлийн нэг хувилбар болох ний, ны-г эм үгэнд пе, эр үгэнд ихэд урагшлуулж па буюу бараг пе шиг хэлнэ. Мөн харьяалахын тийн ялгалын -ээн, -айн гэсэн нөхцөлтэй ба ихэнх тохиолдолд ээн гэдгийг хэрэглэнэ. Жишээ нь: ахээн- ахын эгчээн- эгчийн

16. Заахын тийн ялгалын ээг(a̋g) гэсэн нөхцөлтэй. Жишээ нь: ахээг- ахыг, ээжээг(ēdža̋g)- ээжийг

17. Олон тооны "чууд,чүүд" дагаврын оронд "чоол, чөөл"-г хэрэглэнэ. Жишээ нь: өвөгчөөл, залоочоол

18.Гарахын тийн ялгалын -аас, -ээс (a̋s) нөхцөлтэй.

19.Хоромхон үйдлэх байдлын "с, с+гэ" дагавартай. Жишээ нь: татас гэ-татасхий, явас гэж байгаарай-явсхийж бай

20. **"а, бү" язгууртай үйл үгийн "adag" гэсэн хэлбэрийн тухай.** Доктор, профессор Д.Төмөртогоо монгол хэлний а, бү язгууртай үйл үгийн тухай эрдэм шинжилгээний өгүүлэлдээ: "Эртний ба дундад үеийн монгол хэлний онцлогийг тусгасан дурсгалуудад цагт нэрийн давтан үйлдэхийн дагавраар хэлбэржсэн "adag" хэмээх хэлбэр тохиолдохгүй байгаа боловч орчин цагийн монгол

хэлэнд батлах утгатай "dag" гэсэн нөхцөл байгаа нь эртний монгол хэлэнд "adag"(адаг) гэсэн хэлбэр байсны тодорхой баталгаа болж байна" гэжээ.

Энэ "adag" гэсэн хэлбэр нь одоогийн дархадын аман аялгуунд батлах утгатай идэвхтэй хэрэглэгддэг бүтээвэр юм. Жишээлбэл: ter hun l xelsen adag.-Тэр хүн л хэлсэн адаг. Өгүүлбэрт "adag" гэсэн бүтээврийг хэрэглэхдээ өгүүлбэрийн онцолсон гишүүний ард ихэвчлэн онцлон ялгах бүтээвэр "л" хэрэглэдэг байна.

Мөн "асан" гэсэн хэлбэр ч одоо идэвхтэй хэвээрээ хэрэглэгдэж байна. Жишээлбэл: Xot yabax asan.-Хот явах асан.

Үгсийн сангийн онцлог

Ер нь нутгийн аман аялгууны өвөрмөц үг нь үүх түүх, соёл заншилтай холбогдохоос гадна, эртний хэлний сонин үзэгдлийг хадгалсаар байдаг билээ. Үүнд хоёр үгийг авч үзье.

1. Тангалай гэсэн үгийн улбаа. Дархад нутагт манай эриний V-VIII зууны үед түрэг угсааны Чик аймаг, Шишгэдийн сав газраар нутаглаж байгаад Алтайн Түрэгт эзлэгдэж өрнө зүг түрэгдэн шахагдаж, тэр нутагт нь түрэгийн хуулар болон бусад овог аймгийнхан нутаглаж, тэдний удам угсаа одоо хүртэл уламжлан амьдарч байна. 555 онд Түрэгийн III хан Кигинь, Туваад одоогийн нутаглаж байсан овог аймгуудыг эзлэн авчээ. Мөн энэ үед дархад нутаг Түрэгийн хараанд орсон бололтой.

Түрэг угсаатны соёлын ноёрхол XIII зуун буюу монголчуудын байлдан эзлэх хүртэл үргэлжилжээ. 581 онд Түрэгийн анхны тулгар төр хоёр хуваагдахад Туваа, дархадын хязгаар, Зүүн Түрэгийн хараанд байжээ.

Дархадын нутагт эртний түрэг угсаатан овог аймгууд Чикийн үеэс нутаглаж байсны маргаангүй нэгэн чухал баримт нь дархад нутаг дахь Түрэг гаралтай олон газар, усны нэр байгаагаар нотлогдож байна. Жишээ нь: дархадын аман аялгуунд хэрэглэгдэж байгаа "танг.ай" (тагнай) гэдэг үгийг түрк хэлэнд ч "танглай" гэж хэлж байгаа нь нутаг нэгтэй байсны баталгаа мөн болно.Сонирхолтой нь утга зохиолын хэлний "тагнай" гэдэг үгийг одоо дархад, хотгойд, буриад аман аялгуунд л "танглай" гэж хэлдэг байна. Энэ бол "танг-най, танг-лай гэсэн бүтэврийн завсар "га" гэсэн оруулбар бүтээвэр шургаснаас үүссэн хувилбар үг юм.

2. Ой модны охин тэнгэр гэсэн үгийн улбаа. Ш.Гаадамба " МНТ" судлалын зарим асуудал" (УБ.,1990) номдоо "Профессор

Г.Д.Санжеев 1927 онд тусулсын хойд хязгаар нутгийн дархадуудаас олон үлгэр домог бичиж цуглуулаад 1931 онд Ленинград хотод ""Дархатский говор и фольклор" гэдэг ном хэвлүүлсний дотор "Олон гар" гэдэг үлгэр орсон байна. Энэ үлгэрт нэг нэхмэлчин хүн эхнэрийнхээ зааврааp нэхмэлийн суурь хийх мод авахаар ойд очоод мод бүхэн сайхан санагдаад хайрлаад огтолж сэтгэл түвдэхгүй явж байтал түүнтэй "модны Чинчит хаан ногоон дээлтэй тааралдсан" тэр модны хаан Чинчит модыг хайрлаад огтлоогүйд нь баярлан миний модыг бүү огтол. Оронд юу дуртайгаа надаас ав гэсэнд тэр хүн олон гараараа данз нэхэж амьдрах гэтэл тэндхийн хүмүүс буг чөтгөр байх гээд алчихсан тухай гардаг. Энэ үлгэр бол "Бодуа таны аймгийн үлэмж ном утгыг гийгүүлэн үйлдэгч зул, үлгэрийн ном эрдэнэ цогцолсон лэкша тайлбар оршив" гэдэг номын монгол орчуулгын 118-р хуудсанд байгаа үлгэр бөгөөд тэнд "Шугуйн охин тэнгэр" nags-kyi-Lha-mo гэснийг нь дархдууд амаар ярихдаа "Модны хаан Чинчит хаан" гэсэн нь нэн сонирхолтой.

Шугуй (модны) охин тэнгэрийг дархадын аялгуунд "Чинчит" гэж нэрлэсэн ба энэ үг нь "ой модны охин тэнгэр" гэсэн үг ажээ.

Дархад аялгууны "ч" авиа бол халхын аялгууны "ш" авиатай тохирдог учир тохиолдол бий. Жишээ нь "МНТ"-нд "Ойрад-ун Худага бэхи ой тэмэчэн Шискис зорин хөдөлжү" гэсэн өгүүлбэр байдаг нь одоогийн Шишгэд голын нэр мөн бөгөөд дархад аман аялгууны зарим баримтад "Чишгид" гэж тэмдэглэгдсэн байна.

Иймд дархад аялгууны "Чинчит" гэсэн нь халхын "Шиншитү" буюу "Шинчитү" гэсэн үгтэй тохирох юм. Ингэж үзвэл "Шинчи баян-урианхай" гэсэн нь "ойн (охин) тэнгэр баян урианхай гэсэн утгатай үг байж болно. Энэ "Чинчүтү" буюу "шиншитү" "МНТ-ны "шинчи" гэсэн үгс аль аль нь угтаа shin gehod (мод огтлох) гэсэн төвд үг дээр "чи" гэсэн бүтээвэр залгаж "модочи" гэсэн утгатай үг үүсгэсэн байж болох юм." гэж бичсэн байна. Бид бас энэ дүгнэлттэй санал нэг байна. Дархадууд нь эрт дээр цагаас уул усаа эзэнтэй гэж үзсээр ирсэн нь тэдний үлгэр домогт элбэг тохиолдоно.

Бид дархад аман аялгууны халх аялгуунаас ялгаатай хэлдэг 2200 гэруй үгийг түүж тольчлон тайлбар хийлээ.

Дархад аман аялгууны халх аялгуунаас ялгаатай хэлдэг үгийн товч толь

А

Аажоо аажуу; аажим

Аажоодоолах аажуудуулах; аажуу тайван гэдгийн үйлдүүлэх хэв

Аалзархоо аалзархуу; аалзтай төстэй

Ааль үгээ аальгүй ичгүүргүй; их инээж аальгүйтэх

Аанээ аанээ загас, намар цагт загас таргалсан байх үе нь

Аандаа яваандаа; цаашид болох, аяндаа

Аа оодээ хүүе! хүү /охин/ минь гэж хүүхдийг дуудсан үг

Ааруул ааруул; зүсэж буюу хэвэнд хийж хатаасан аарц

Аархоо аархуу; омогтой, дээрэнгүй

Аатанк эсгий гутал; малын үс ноосыг ашиглан хүйтний улиралд хөлд өмсөхөөр хийсэн гутал

Аа чамай болж дээ; уулга алдсан үг

Аббал авбал; юмыг өөрийн болгон авах үйл үгийн болзох хэлбэр

Абдар авдар; хайрцгаас том, дөрвөлжин хэлбэртэй, дээрээ буюу урдаа нээлхий хавхагтай эд юм агуулах гэрийн хогшил сав

Абсаархан жижиг эвтэйхэн

Абцаа авцаа; бусдаас авах өр

Авалцах 1. хэрэлдэх 2.үг хэлээ авалцах (бусадтай үг нийлэх) 3. зангаа авалцах (бие биенийхээ занг танин мэдэх) 4. авалцан наалдах, авалцан хөлдөх (аливаа нэг юманд наалдах, салахгүй байх) 5. гал авалцах (шатах)

Авнав Би авъя

Авноот Та авна уу?

Авноч Чи авах уу?

Авраа хөрөө түлээ хөрөөддөг том хөрөө

Агноо агнуур; ан гөрөө

Агрих 1. таг хөлдөх 2. агирсан гартай, мэдээ муутай гартай, хөгширч юм барьж чадахаа больж багаа гэсэн утга

Агсарга дээлийн ар талыг хөөргөж бүслэх

Агсгадах морь мал унаж явахдаа ядарч зүдрэх

Агоо 1. агуй; уул хаданд тогтсон гадагшаа гарах

амсартай их хонгил 2.агуу; агуу их

Агоолах агуулах; аливаа зүйлийг хурааж хадгалах

Агшаамал агшаасан будаа

Агшоон агшуун; эврүүн

Адаар адайр; зан муутай

Адаг "а" язгууртай үйл үгийн тодотгон холбох хэлбэр. Ах л хэлсэн адаг-Ах л хэлсэн дэг.

Адар байшингийн дотор дээвэр, тааз

Адгоо адгуу; яаруу, тэвдүү

Адгоос адгуус; хүнээс бусад амьтдыг нэрийдсэн нэр

Адсага 1. турж үхсэн малын арьс 2. дэвсгэр болгон хэрэглэх үхэр малын хатсан шир 3. адууг хараасан үг муу адсага чинь гэх мэт

Адоо адуу; битүү туурайтны нэрийтэл нэр

Адоочин адуучин; адуу маллах хүн

Аёолтээ аюултай; айвал зохих зүйл

Ажаа ураг төрлийн доторх ах зах хүнийг, голдуу эмэгтэй хүнийг хүндэтгэн цээрлэж нэрлэсэн нэр

Ажал ажил; ажил үйл, хөдөлмөр

Ажар(азар) их үстэй; азар толгойтой сарлаг- толгойдоо их үстэй сарлаг

Азаргана зүлэг газар ургах нэгэн зүйл ургамал, навч урт, навчны захаар өргөстэй, үндэс, голыг нь идэж болдог

Азрага 1. түлээ хөрөөдөхөд зориулж хийсэн , дөрвөн хөлтэй нэг төрлийн тавиур маягийн зүйл; 2. бусад утга нь халх аялгуутай адил

Айвалхээ аюулхай; өвчүү хоёр сүврэг ясны хооронд аймхай мөгөөрсний тус газар, айвилхай

Дархад аялгуунд "ай"- гийн хосыг ихэд урагшилсан **ā**-гаар бараг урт "ээ" шиг хэлдэг

ādăs айдас; аймшиг

ādzăm айзам; нэгэн хүчтэй өргөлтөөс нөгөө хүчтэй өргөлт хүртэлх хэсгээр хэмжигдэх хөгжмийн аялгууны хэмжээний нэгж

āl айл; нэг гэр өрх

āldăx айлдах; дээд хүмүүст үг сургаал хэлэх

āltĕ ùgē айлт үгүй; айх хэрэггүй

āltē айлтай; 1. аймаар, аймшигтай 2. хөрш айл байгаа 3. гарамгай

āltšĭŋ айлчин; зочлон ирэх хүн

āltšĭlăl айлчлал; айлчлах үйлийн нэр

āltšĭlōlăx айлчлуулах; айлчлахын үйлдүүлэх хэв

āmăg аймаг; засаг захиргааны нэг нэгж

āmăglăx аймаглах; юмыг анги төрөл, хэсэг болгон хуваах

āmăglōlăx аймаглуулах; аймаглахын үйлдүүлэх хэв

āmtgē аймтгай; аймхай

āmšĭg ùgē аймшиггүй; айх эмээх юмгүй

āmšĭgtē аймшигтай; зэвүүцмээр аймаар

ārăg айраг; гүүний сүүг хөрөнгөлсөн исгэсэн нэг төрлийн унд

ārăgdăx айрагдах; айраг ихээр ууж найрлах

ārăglăx айраглах; исэж сагсан юм

āsō айсуу; аливаа зүйлийн ирж яваа утга заана

āx айх; юмнаас айх сүрдэх

Албаар зориуд; зориуд хүчлэх гэж хэлэхийг албаар хүчлэх

Алгоор алгуур; яаралтай биш

Алдоол алдуул; алдсан мал

Алдоорах алдуурах; уяатай байсан амьтан уяа нь тавигдан явах

Алхих зодох; нэлээд сайн зодох

Алчоор алчуур; 1. юм арчихад зориулсан зүйл 2. толгой бооход зориулсан эд

Амгээ амгай; морь малын аманд үмхүүлэх нарийн дугуй төмөр

Амроолах амруулах; амраах

Амьдээ амьдай; ижил нэртэй хүмүүс бие биеэ **дуудах**

Амьтээ амьтай; 1.хувьдаа тохирсон эд хөрөнгөтэй 2. бусад утга нь халх аялгуутай ижил

Ангалзоор 1. малын үс хяргадаг хайч 2. шувууны зулзага 3. аальгүй аманцар

Анги 1. бусдаас өөр ондоо 2. анги бүлэг

Ангоочин ангуучин; анчин гөрөөчин

Ангоочлах ангуучлах; ан хийх

Андар ааруул хатаах дэлгэц

Андоо андуу; ташаарах, эндүүрэх

Анзандах худал ярих

Анивчоор нүдээ байн байн анивчих

Аничих нүдээ байн байн анивчих, гэрэл ойр ойрхон асаж

	унтрах
Арагшаан	рашаан; ямар нэгэн өвчин эмгэгийг анагаах чадал бүхий эрдэст ус
Араажав	радио; тусгай станцаас явуулах цахилгаан соронзоны долгионоор дуу ба тэмдэгийг утасгүй илгээх, хүлээн авах арга
Аранга	1.эд юманд халтай 2.бусад аялга нь халх аялгуутай ижил
Арас	арьс; хүн амьтны биеийн гадуур бүрхүүл
Арваалж	аалз; нэгэн төрлийн амьтан
Арвижөөлөх	арвижуулах; арвин их болгох
Аргамж	морь малыг бэлчээрлүүлэн уяхад зориулсан дээсэн урт оосор уяа
Аргил	хашир догь, аргил мод /хөгшин мод/
Ардаг	догшин, хал үзээгүй, атар тарган
Ариөн	ариун буртаггүй, цэвэр
Арнигчих	их гүйсний дараа багтрах баахан амьсгаадах, арнигч үхтлээ гүйх
Арсалдах	тэмцэлдэх, шөргөөцөлдөх
Архаг	бөс даавууны хоёр талын зах ирмэг
Арчоол	алчуур;1. толгой боох зүйл 2. юм цэвэрлэх, угаахад зориулсан алчуур
Арч үгээ	арчаагүй; аливаад овсгоогүй, аминдаа арчаагүй
Асоо	асуу; юмыг мэдэж авахын тулд лавлах утга
Асоолт	асуулт; асуух үйл үг
Асаагоор	асаагуур; тамхи асаах хэрэгсэл
Ахиохан	ахиухан; нэлээд их хэмжээтэй
Ахар	богино; охор
Ахооно	ахууна; цэнгэг уст нуур цөөрөмд өндөглөдөг, загасан идэштэй, арьс нь үслэг анд ордог нэгэн зүйл шувуу
Ац	1. аль надад өг 2. өвсний ац
Ацаглах	өөрт оногдсон ажлыг бусдаар хөлс төлж хийлгүүлэх
Ачмаг	морь малын нуруунд юм ачихад зориулж хийсэн нэг төрлийн арьсан сав
Ачоолах	ачуулах; юм ачихын үйлдүүлэх хэв
Ашаг	ашиг; ашиг орлого
Аялгоо	аялгуу; дуу хөгжмийн аялгуу

Б

Баадан	ваадан; юм боож орооход хэрэглэх дервөлжин хэлбэртэй зүйл
Баадагнах	ваадагнах; бааданд юм ороож боох
Баалах	1. идээлэх, өвчин хүндрэх 2.бөөгийн онгод уурлаж догшрох 3. будаа гурил зэрэг хүнсний зүйл чийг авснаас болж тогтсон хөгц мэт ногоовтор зүйл тогтох
Баарах	буу гацах
Багалзоор	багалзуур; амны хөндийг улаан хоолойтой холбох суваг
Багачоол	багачуул; бага насны хүүхэд
Бадаа	цайны доромж нэр, муу хар бадаагаа харамлах
Бажигдах	сандрах; тэвдэх
Бажууна	ургамал; гишүүний үндэс
bāgǐx	баагих; утаа багсран гарах
bā	бай; 1. харваж онохоор босгосон шав 2. мөрий шан 3. байг, боль гэсэн утгатай үйл үг
bāγā	байгаа; буй
bāgǐl	байгаль; байгаа бүх сав, шим ертөнц
bāγōlăγdăx	байгуулагдах; байгуулахын үйлдүүлэх хэв
bāγōlăγčǐ	байгуулагч; зохиогч, үүсгэгч
bāγōlămdžǐ	байгууламж; ямар нэгэн зохион байгуулсан юмны явцын шинж төрх
bāγōlăx	байгуулах; үүсгэх бий болгох
bādăl	байдал; аливаа юмны янз дүр төлөв
bādăs	байдас; шүдлэн, хязаалан насны гүү
bālγăx	байлгах; үлдээх, тогтоох, бүй болгох
bāldāŋ	байлдаан; бага хэмжээний газрыг хамарсан тулалдаан
bāldăγtšǐ	байлдагч; жагсаалын цэргийн албан хаагч
bāldăx	байлдах; байлдаан хийх
bāltsăx	байлцах; байхын үйлдүүлэх хэв
bāltsōlăx	байлцуулах; байлцахын үйлдүүлэх хэв
bāmγā	баймгай; нас бие гүйцсэн, том

bā̆ŋγă байнга; үргэлж, дандаа
bā̆r байр; орогнон орших газар
bā̆rĭŋ байрин; суурин
bā̆răγšĭx байргаших; нас бие гүйцэх
bā̆răγšū байргашуу; байр төлөвөө олсон
bā̆r ügē байргүй; 1. ул суурь муутай 2. орон сууцгүй
bā̆rlă̆x байрлах; нэг газар байрлах
bā̆rlōlă̆x байрлуулах; байрлахын үйлдүүлэх хэв
bā̆ršĭx байрших; байрин суурин
bā̆ršōlă̆x байршуулах; байршихын үйлдүүлэх хэв
bā̆tă̆l байтал; атал
bā̆x байх; оршин тогтнох
bā̆x ügē байхгүй; үгүй, эзгүй, алга
bā̆xō байхуу; дулаан газар ургадаг, үсэрхэг цагаан үртэй, хүрэн навчтай нэг зүйлийн цайны ургамал
bā̆ts байц; хавцал бэрх газар
bā̆tsā байцаа; хүнсний нэг төрлийн ногоо
bā̆tsāγts байцаагч; аливаа хүний ажил, алдаа оноог хянан шалгах, зааварлах үүрэгтэй албан тушаалын хүн
bā̆tsāx байцаах; хянан шалгах үйл
bā̆šĭŋ байшин; хүн амьдрах, юм агуулахад зориулсан мод, төмөр, шавар, туйпуу, чулуу зэргээр барьсан барилга
Балиөс балиус; 1. нэг төрлийн загас 2.том хутга
Балт түлээний том сүх
Бандан вандан; юм тавихад зориулсан тавиур
Бараан хар; 1. бараан хүн 2. бусад утга нь халх аялгуутай ижил
Бараа хурааж овоолж зүйл, барааны байшин- илүү зүйлээ хураах байшин
Барав малын арьсаар хийсэн малын том жижиг сав
Баржгар барзгар; баржгар хар
Баржээх баржийх; барзгар болох
Бариөвч бариувч; бага хүүхдийн дээл
Бариөл бариөл; 1. аливаа юманд барихад зориулж хийсэн иш гогцоо сэнж 2. юмыг барихад жийрэг болгон хэрэглэх зүйл
Барлаг зарц боол
Бартан цоохор; бартан хайнаг

Барчгар 1. олон 2. овгор товгор 3. цоохор
Батхана нэгэн зүйлийн ялаа
Бахан тэгье ингэе гэсэн утгатай үг, (бахан сайн эрийн үг, асан муу эрийн үг гэсэн зүйр үг хүртэл байдаг)
Бахим хээнцэр биш бөх бат
Бахлоор бахлуур; зуухны яндан байрлах хэсэг орчмын хамгийн ар талын хэсэг
Бач заль мэх
Бачмаг бачим; бачмаг хүн
Бачоо бачуу; давчуу бариу
Баяжоолах баяжуулах; юмаар баян болохын үйлдүүлэх хэв
Баярхоо баярхуу; эд юмаараа гайхуулах
Баячоол баячуул; чинээлэг, эд хөрөнгөтэй баян хүмүүс
Бийлөөлөх биелүүлэх; гүйцэтгэх
Бижгэн бага охин
Бижиг жижиг, бага
Бижрөө бижрүү; биеэнд туурсан жижиг гөвдөрүү
Билзэг бөгж; юманд чимэг болгох ба бэхлэхээр хийсэн зүйл
Бийлэгжөө бийлэгжүү; чинээлэг
Билөө билүү; хутга хайч зэргийг үрж ирлэх зөөлөн чулуу
Билөөдэх(бүлөөдэх) билүүдэх; хутга билүүдэх
Бирд харамч
Бирхрэх чанга дуугаар уйлах
Битгээ битгий; бүү боль
Битөө битүү; задгай гэсний эсрэг утга
Битөөдээ битүүдээ; далдуур
Битөөлэг битүүлэг; учир утга нь ил бус
Битөөлэх битүүлэх; 1. битүү болгох 2. билгийн улирлын битүүний өдөр ёслол үйлдэх 3. эд юмсыг харахгүй, үнэ хэлэлцэлгүй солилцох
Битөөмжлэх битүүмжлэх; сав баглаа зэргийн ам амсар нүх сувийг нээлгэхгүйн тулд битүүлэн наах ба лацдах
Бичгэн 1.эмэгтэй хүүхэд 2.бага, жижиг
Бичөөлэх бичүүлэх; бичихийн үйлдүүлэх хэв
Биш даа, дээ даган чимэх үг . авахаас биш- авъя даа
Бишгөөр бишгүүр; хөгжмийн зэмсэг
Бишиндээ бусдадаа; бусад хүмүүстээ
Бишнэр бусад хүмүүс
Бишрөөлэх бишрүүлэх; сүсэглэн хүндэтгэхийн үйлдүүлэх хэв
Бишөөрхөх бишүүрхэх; гэрэвших

Биштэргэнэ нэг төрлийн шувуу, муур шиг толгой нүдтэй, бор шувуу шиг өнгөтэй, харцага шувууны чинээ шувуу
Богис богоч; морь малын урд хөлийг бохируулан сойх сур дээс
Боголзоор багалзуур; амны хөндийг улаан хоолойтой холбох суваг, төвөнхий орчмын газар
Богц богц; юм агуулж эмээл дээгүүр тэгнэхэд зориулсан ширэн сав
Бодоолох бодуулах; тоо бодох
Болгаамж болгоомж; хянах
Болзаа болзоо; урдаас тогтсон хугацаа газар
Болзар үгээ болгоомжгүй; хянуур биш
Болиолах болиулах; болихын үйлдүүлэх хэв
Бололцаа бололцоо; боломж
Болцоо болцуу; сонгинын болцуу
Боо буу; гол төмөртэй галт зэвсэг
Боодаг уяа; 1. юм боох оосор бөс даавуу зэрэг зүйл 2. тарвагны боодог
Боодал буудал; 1. явуулын хүний хоноглох , байрлах газар 2. багласан юм
Боодас 1. хаалт, саад учруулах 2. уяа
Боодах буудах; бай буудах
Боожох бойжих; өсч торних
Боожоол бойжуул; өсч торнихын үйлдүүлэх хэв
Бооз бууз; бууз идэх
Боолгах буулгах; аливаа зүйлийг дээрээс доош болгохын үйлдүүлэх хэв
Бооль буйл; тэмээний хамарт хийж бурантаг уях мод
Боолих буйлах; тэмээ уянгалан дуулах
Боолиолах буйлуулах; буйлуулахын үйлдүүлэх хэв
Боомал тарган хур таргатай, хүн унаагүй морь
Боорал буурал; буурал ээж
Боорь буйр; 1. байр орших газар 2. ул суурь
Боох буух; намаржаандаа буух
Боохалдай четгер; далдуур хорлох хий зүйл
Боохай чоно; нохойн төрлийн сүүн тэжээлт махчин амьтан
Боожих бойжих; өсөх торних
Бораа бороо; хур
Бораалах бороолох; ясны хугарал эдгэрэх

Боргошоо боргошуу; хатуужил тэсвэртэй
Борлон хоёр настай ямаа буюу шүдлэн ямаа
Борлоолах борлуулах; 1. бор өнгөтэй болгох 2. мах борлуулах 3. эд бараа зарах
Бортого жижиг модон хувин
Борчээ эр хүний бэлэг эрхтэн
Борших шөл, цай зэргийн зүйл удаан өтгөрч буцлах
Босаа босоо; эгц дээш
Босхоол босгуул; оргож буруулсан
Бохирах бохирох; хүн амьтны хөл нугарах
Боэв бойтог гутал
Боэдан буйдан; орны хэрэгсэл
Боэль буйл; тэмээний хамарт хийж бурантаг уях мод
Боэлоол буйлуул; ингэ буйлуулах
Боэм 1. бугуйл цалам 2. боож үхэхэд хэрэглэх зүйл
Боэрь буйр; байр суурь
Боэтаг бойтог гутал
Бөглээ бөглөө; аливаа юмыг таглах
Бөглөө бөглүү; алс хол хүн амьтан очоогүй газар
Бөгтрөх нугалан юмны дээгүүр тохож тавих
Бөжин бүжин; туулай
Бөлзөг бөгж; хуруунд зүүх чимэг
Бөлдөг эрэгтэй хүний бэлэг эрхтэн
Бөлцээх бөлцийх; аньсаг зовхи цэлцгэр, хөөнгтөн бөлцийх
Бөмбээх бөмбийх; бөөрөнхий хэлбэртэй болох
Бөмбөгдөөлэх бөмбөгдүүлэх
Бөмбээхээ бөмбөөхий; нялх зүйлийг өхөөрдөн хэлэх
Бөндээх бөндийх; бөндгөр болох
Бөө 1. бүү битгий 2. бөө хүн
Бөөв хүүхдийн өлгий ор
Бөөлжөөлэх бөөлжүүлэх; ходоодонд байгаа юмыг огиж гаргах
Бөөлэх бөөлөх; бөө онгод тэнгэрээ дуудан бөөлөх
Бөөрөнкээ бөөрөнхий; бөмбөрцөг, бөмбөгөр, бөмбөг мэт хэлбэртэй
Бөөрөнкээлэх бөөрөнхийлөх; 1. бөөрөнхий болгох 2. бөөрөнхий үзэл гаргах
Бөөрцэг бөөрцөг; хэдэн юм, цөөн,тусдаа, бөөрцөг хонь
Бөөцээлэх бөөцийлөх; энхрийлэх, арчлах
Бөртээх бөртийх; алсад торойж харагдах
Бөсгөх малын уураг чанах, уураг бөсгөх

Бөхжөөлэх бөхжүүлэх; бат бэх болгох
Бөхөнө шумуул; хүн амьтныг хатгаж цусыг нь сордог нэг зүйлийн бяцхан ялаа
Бөхээх унтраах; лаа бөхээх /лаа унтраах /
Бөхөлзөөлэх бөхөлзүүлэх; бөхгөр юмны бөхөс бөхөс хөдлөхийн үйлдүүлэх хэв
Бугиоль бугуйл; адуу мал барих үзүүрт нь гогцоо гаргасан урт суран оосор
Бугоо бугуй; гарын бугуй
Бугших үүрлэх; нэг газар орогнох
Будоолах будуулах; өнгө оруулах
Бузартоолах бузартуулах; бузар болгох
Буйдан гудас; орон дээр тавьдаг хэрэгсэл
Булаацалдах булаацалдах; булаан авах үйл
Булгаар булгиар; булгаран цунх-үхэр адууны ширийг боловсруулан, ханан хээ гаргаж хийсэн цүнх
Булдроо булдруу; булцруу, есөн булдруутай хэнгэрэг
Булжих хөл гарын үе гэмтэх
Булзааруулах булзааруулах; ямар нэгэн юмаар шалтаглах, дүйвүүлэх
Булоо булуу; чөмөг ясны үзүүрийн бүдүүн яс
Булоолах булуулах; булахын үйлдүүлэх хэв
Булрах ядрах; бие булрах
Булчирхээ булчирхай; бие мах бодод хэрэгтэй бодисыг боловсруулах буюу хэрэггүй бодисыг гадагшлуулах эрхтэн
Булхээ булхай; гүтгэлэг
Булээ булай; жигшмээр
Бумбат толь хишгийн савны суманд байдаг толь
Бургаас бургас; модлог ургамал
Бурио бяруу; хоёр настай үхэр
Буроо буруу; зөвийн эсрэг утга
Буроодах буруудах; зөв биш болох
Бусрах хийсэн хэлснээ дахин буцаах
Буумал толь арван хоёр жилийн дүрстэй бөөгийн толь
Бушоо бушуу; хурдан
Бүгшөөлэх бүгшүүлэх; бүгшин ханиах
Бүдөөвч бүдүүвч; тойм, багцалсан
Бүдөөлөг бүдүүлэг; 1. уран гоё биш болсон 2. эрдэм соёлгүй хоцрогдсон

Бүдөөн бүдүүн; нарийны эсрэг утга
Бүжиглөөлөх бүжиглүүлэх; бүжиг хийхийн үйлдүүлэх хэв
Бүлээрэх халуурах; хүүхдийн бие нь бүлээрсэн байна- хүүхдийн бие нь халуурсан байна
Бүрөөлөх бүрүүлэх; 1. өнгөлөх, гадарлах үйлийн үйлдүүлэх хэв 2. халуун бүлээн сүүнд хөрөнгө хийж бүгнэн исгэх үйлийн үйлдүүлэх хэв
Бүтөө битүү; задгай гэдгийн эсрэг утга
Бүүл буйл; хүний шүдний буйл
Бэдрэх хайх; эрэх сураглах
Бэсрэг бага; 1. хэмжээгээр их биш 2. тоо цөөн
Бялоо бялуу; амтат бялуу
Бярдах өвдөх; өвчин тусах
Бяроо бяруу; хоёр настай үхэр
Бяцлах буцлах; 1. шингэн юм зуун градус хүртэл халж оргилон буцлах 2. буталж жижиглэх

Г

Гааглах ихэд чанга дуугаар хашгирах, загнах
Габшагээ гавшгай; шалмаг хурдан
Гагноолах гагнуулах; гагнахын үйлдүүлэх хэв
Гагноор гагнуур төмөрлөгийн зүйлийг гагнах
Гагноорчин гагноорчин, гагнуур хийдэг хүн
Гадаргоо гадаргуу; дэлхийн гадаргуу
Гадар гар нүүр угаах түмпэн сав
Гадоор гадуур; дотуур гэдгийн эсрэг утга
Гадоорхах гадуурхах; гадуурхах үзэл
Гажаг гажиг; согогтой
Гажоо гажуу; 1. санаа явдалд тохирохгүй буюу зан авир зөрүүд 2. тойруу зам
Гажууд гажууд; дүрэм журмаас гадуур этгээд
Газаа гадаа; дотор биш гэсэн утга
Газарзөө газарзүй; нэг шинжлэх ухааны нэр
gā гай; зовлонгийн шалтгаан
gā ügē гайгүй; бэрхшээл төвөг багатай амар хялбар зүйл
gātā гайтай; гай бүхий юм
gātăx гайтах; гай тусах
gātōlăx гайтуулах; гайтахын үйлдүүлэх хэв
gāxăydăx гайхагдах; гайхахын үйлдэгдэх хэв

gā̆xă̆ltā̆ гайхалтай; ер бишийн гайхам юм
gā̆xă̆mšĭg гайхамшиг; онцын сайн шилдэг зүйл
gā̆xă̆x гайхах; үйл явдлыг шийдвэрлэж үл чадан тээнэгэлзэх
gā̆xă̆š гайхаш; гайхшаа барах
gā̆xōlă̆x гайхуулах; гайхахын үйлдүүлэх хэв
Галзоо галзуу; 1. ухаан мэдрэлээ алдаж солиорох 2. ууртай догшин 3. эртэй чадалтай, тухайн зүйлээс илүү
Галоо галуу; нэг төрлийн шувуу
Гаргоо гаргуу; бусдаас давуу
Гаргоол гаргуул; хогийн гаргоол
Гатилбар бохирдож гатлагдсан ус
Гатлоолах гатлуулах; гатлуулахын үйлдүүлэх хэв
Гахээ гахай; том биетэй, ац туурайтай, сүүн тэжээлтэн амьтан
Гацоо гацуу; ядуу, зүдүү, ховор хомс
Гацоор гацуур; мөнх ногоон нэг төрлийн мод
Гашоодал гашуудал; үхэл хагацал тохиолдсоноос болж учирсан харамсал
Гашоон гашуун; 1. хэлний сэрэгдэхүүнд үл таалагдах нясуун амт 2. энэлэл зовлон, уйтгарлал
Гиван мөнх мөсний хөөс
Гивлөөр гивлүүр; эмэгтэйчүүдийн нүүр халхлах алчуур
Гижигнэх гижигдэх; гижгий нь хүргэх
Гийгүүлэгч гийгүүлэгч; уушигнаас гарсан хий амны хөндийд ямар нэгэн саад бэрхшээлтэй тохиолдож бий болсон авиа
Гилжгээ гилжгий; хүзүү нь хазгай
Гилжрэв дугуй цагираг эзмэг
Гингэнэх бага зэргийн дуу гарган уйлах
Гинжлөөлөх гинжлүүлэх; юм гинжлэхийн үйлдүүлэх хэв
Гирэвших гэрэвших; хүнийрхэх
Гичээ гичий; 1. охин чоно, нохойн нэр 2. хараалын үг
Гижгэнэ гичгэнэ ургамал, уламжлалт анагаах ухаанд хэрэглэнэ
Гишгэх явах; гишгэж л байгаач- чи явж л бай
Гишгэн татах хурдан явах
Гишөө гишүү; модны мөчир
Гишөөн гишүүн; олон нийтийн ямар нэгэн байгууллагад

сайн дураараа элссэн хүн
Гишөөнө гишүүн; бажууна ургамал
Гиеөрэх гиюүрэх; санаашран уйтгарлах
Говирхоо говирхуу; говийн шинжтэй
Гових морь мал гэдсээ авах, турах
Гогцаа гогцоо; юмны барьж өлгөж болох сэнж
Гогцаалдах гогцоолдох; утас, дээс, сур зэргийн үзүүрийг эгэлдэрч гогцоолдон уях
Гогцаарах гогцоорох; юм ээдэрч гогцоо гарч сэнжтэх
Гозээх гозойх; гозгор болох
Гойрхох илүү үзэх, авахыг санаархах
Голгээ олгой; хүн ба адгуус амьтны бүдүүн гэдэсний шувтрах хэсэг
Голдоо голдуу; тухайн юмны ихэнхийг эзэлсэн хувь
Голцоо голцуу; ихэнхдээ
Тавьжээ хувь зэяа; тавьжээ минь тийм байж- хувь заяа минь тийм байж
Тагваа Лхагваа; хүний нэр
Тагжгар хэвийн хэмжээнээс огтор богино
Тагжээх тагжийх; тагжгар болох
Тагноол тагнуул; тусгай зорилгоор ямар нэгэн юмыг нууц аргаар мэдэх
tā̆wō тайвуу; уужим тайван байдалтай, тайвуу хүн
tā̆dz тайз; жүжиг, концерт тоглоход зориулсан тавцан
tā̆lă̆g тайлаг; гурваас таван нас хүртэлх тэмээ
tā̆lōlă̆x тайлуулах; тайлахын үйлдүүлэх хэв
tā̆rdă̆s тайрдас; тайрагдсан юм
tā̆tɣă̆rōlă̆x тайтгаруулах; сэтгэл засагдаж, дотор уужрах; тайтгарахын үйлдүүлэх хэв
Талиэх талийх; арилж өгөх; бараа сураггүй хол явчих
Таллоолах таллуулах; юмыг дундуур нь хуваах, хагаслахын үйлдүүлэх хэв
Тамгалоолах тамгалуулах; тамга дарах, бичиг тамаглахын үйлдүүлэх хэв
Тамир үгээдэх тамиргүйдэх; хэтэрхий тамиргүй болох
Тамлоолах тамлуулах; тарчилган зовоох, бөө нарын онгондоо залбирахын үйлдүүлэх хэв
Тамшаалах идэж уухдаа тоомсоргүй хандах, тоож идэхгүй байгаа янз гаргах
Тангла̄ тагнай; амны доторх дээд хонхор тал
Тандоолах тандуулах; юмны байдал төлөвийг ажиглан туршиж явах, тандахын үйлдүүлэх хэв
Танигдаш үгээ танигдашгүй; танихын аргагүй
Танил үгээ танилгүй; таних олон нөхөргүй
Танилцоолах танилцуулах; танилцахын үйлдүүлэх хэв
Таних үгээ танихгүй; мэдэж ялгаж чадахгүй, хүн танихгүй
Таншгар ихэмсэг; их зантай, хэр баргийн юмыг тоохгүй
Таргалоолах таргалуулах; тарган болохын үйлдүүлэх хэв

Тариолах тариулах; тарихын үйлдүүлэх хэв
Тарлан алаг, эрээн, алаг цоохор
Тармоол тармуул; хадсан өвс хамах хэрэгсэл
Тармоолдах тармуулдах; тармуурдах
Тасалдоолах тасалдуулах; болих, тасрах, тасалдахын үйлдүүлэх хэв
Тасдоолах тасдуулах; таслахын үйлдүүлэх хэв
Таслах гурил таслах- хоол хийхээр гурил элдэж, хэрчих бэлтгэх
Тасралт үгээ тасралтгүй; цаг үргэлжид, байнга
Татагээ хүүе яанаа гэж уулга алдсан үг
Тахилзоор тахилзуур; шаант чөмөгний зэрэгцээд байх нарийн яс
Тахиолах тахиулах; тахих шүтэх, тахил болгож өргөхийн үйлдүүлэх хэв
Ташир давхар
Ташлаг холтос далны ясаар хийсэн нэг төрлийн хөгжмийн зэмсэг
Ташоо ташуу; хэлбүү, хазгай
Ташоор ташуур; морь мал гуядах хэрэгсэл; хулсан ташуур
Ташоордах ташуурдах; ташуураар жанчих
Тигээд тэгээд
Тигээт Та тэг
Тигээч Чи тэг
Тийрэн чөтгөр
Тийрөөлэх тийрүүлэх; тэмээ, үхэр зэрэг амьтны хойт хөлөөр өшиглөх; тийрэхийн үйлдүүлэх хэв
Тийрэх мал хөлөөрөө хүчтэй хайрах, өшиглөх
Тинтгэр тарган, махлаг
Тихлээр нь тэгэхлээр нь
Тобчаа товчоо; ямар нэгэн зүйлийг эрхлэх албан газар
Тобшох товших
Товорцог тоорцог; бөмбөгөр хэлбэртэй нэгэн зүйл малгай
Товроо товруу; бөөрөнхий, товгор
Товчлоор товчлуур; амьтны эгэм яс ба өнгөлүүр
Тогаа тогоо; идээ болгох сав
Тогаалах тогоолох; галлаж тогоо тавин хоол хош хийх
Тогаач тогооч; идээ хоол хийхдээ мэрэгжсэн хүн
Тогироо тогоруу; өнгө хөхөвтөр, хүзүү хөл урт, сүүл шувтан, хос хосоор явдаг том шувуу
Тогтаал тогтоол; олноороо хэлэлцэж гаргасан шийдвэр буюу засгийн заавар тушаал

Тодорхээ тодорхой; илт, илэрхий, тод
Тожгоноолах тожгонуулах; тор тор чимээ гарч сонсдох, тожигнохын үйлдүүлэх хэв
Толгээ толгой; 1.хүний толгой 2. аливаа юмны дээд хэсэг
Томдоолах томдуулах; хэтэрхий том болгох
Томроолах томруулах; томрохын үйлдүүлэх хэв
Томоо томуу; халдварт ханиад
Тоншоол тоншуул; амьтан тогшуурга шувуу
Тооцаа тооцоо; юмыг тооцож гүйцэтгэх үйлийн нэр
Тоолиадас туулиадас; түр орох бөөрөнхий ширхэгтэй цас
Торээ торой; гахайн торой
Тосгоор тосгуур; юмыг тосгож тавих тавиур
Тохиалдоолах тохиолдуулах; тохиолдохын үйлдүүлэх хэв
Тохироолах тохируулах; тохирохын үйлдүүлэх хэв
Тохээ тохой; гарын атгаал, богтсын нийлэх үе
Тохоолах тохуулах; морь малын нуруун дээр тогтоож бэхлэхийн үйлдүүлэх хэв
Тоэм тойм; бараг барагцаа
Тоэраг тойрог; дугуй
Тоэроо тойруу; чиг, дөт биш, холуур; тойруу зам толгой; нүүр гавал хоёроос бүтсэн, хүн амьтны биеийн эрхтэн
Тоэроолаг тойруулга; юмыг тойрон явах зам
Төвхнөөлэх төвхнүүлэх; орон гэрийн байдлыг сэтгэлд тааламжтай засахын үйлдүүлэх хэв
Төдээ төдий; төдий гэж тэдгээрийг заах үг
Төдээрэнгээ бүгдээрээ, олуулаа, цөмөөрөө
Төдээл төдүүл; өмд зэргийн юмны оосор тогтоох сэнж
төдээлөөлээ бүгдээрээ, цөмөөрөө
Төгцөг хожуул, ургаж байгаа модыг тайрахад үлдсэн үлдвэр
Төлөвлэгээ төлөвлөгөө; хийж гүйцэтгэх ажил үйлдвэрийн урьдчилсан сэдэв
Төлөвлэгээ үгээ төлөвлөгөөгүй; төлөвлөгөө зохиогдоогүй
Төлэг төлөг; 1.хоёр настай хонь, 2. мэргэ төлөг
Төлээ төлөө; орлосон этгээд, эцгийн төлөө хөвгүүн ирэв
Төлээлэгч төлөөлөгч; улс албан газрын буюу ардын нэрийн өмнөөс үүрэг даалгагдсан төлөөний хүн
Төлээс төлөөс; өр төлбөр
Төнкөр эвэргүй, төнхөр хайнаг- эвэргүй хайнаг
Төнкөх ухах

Төртгөр жижигхэн гэж өхөөрдсөн үг, муу төртгөр хурга минь
Төсээ төсөө; төс, царай дүр адил
Төсээ үгээ төсөөгүй; адилгүй, ойролцоо биш
Төхээрэх төхөөрөх; 1.зэхэх, бэлдэх; 2.нядлах, үхэр төхөөрөх
Тулгоор тулгуур; тулах юм, багана, модоор тулгуур хийх
Тумал дуу шуугүй, яриа муутай
Тунирхоо тунирхуу; тунирхаг, тунимтгай
Турсага 1.үхсэн бог малын арьс 2. хараал
Туршоол туршуул; турших үйлийн нэр
Тушмаг адуу малын урд хоёр хөлийг нь холбон бэхлэх нэг төрлийн чөдөр
Түгчээ саад, бартаатай газар
Түүс үйсээр хийсэн жижиг сав
Түүсээ дүрсгүй, сахилгагүй, томоогүй
Тэвдөө тэвдүү; яаруу сандруу
Тэвхээх тэвхийх; тэвхгэр
Тэвхэлзөөлэх тэвхэлзүүлэх; тэвхэлзэхийн үйлдүүлэх хэв
Тэвчиглэх ойр дөт замаар очих
Тэвээлэх замбараагүй болгох; ор дэр тэвээлэх- ор дэрийг замбараагүй болгох
Тэг бөөрөнхий дув дугуй
Тэгнөөр тэгнүүр; юм тэгнэж тавихад зориулсан зүйл
Тэгшлөөр тэгшлүүр; юмыг тэгш болгох зүйл
Тэгшрөөлэх тэгшрүүлэх; тэгшрэхийн үйлдүүлэх хэв
Тэлөөр тэлүүр; юмыг тэлэхэд зориулж хийсэн хэрэгсэл
Тэлөөрдэх тэлүүрдэх; юмыг тэлүүрт тэлэх
Тэмдэглөөлэх тэмдэглүүлэх; юм тэмдэглэхийн үйлдүүлэх хэв
Тэмтрөөл тэмтрүүл; хорхой шавж зэрэг амьтанд их төлөв амны этгээдэд байх хүртэхүйн эрхтэн, юмыг тэмтэрч мэдэхэд зориулсан хэрэгсэл
Тэмөөлэх тэмүүлэх; ямар нэгэн үйл явдалд хүсэн дурлаж, тогтож ядан зүтгэлхийлэх
Тэмцэлдөөлэх тэмцэлдүүлэх; тэмцэлдэхийн үйлдүүлэх хэв
Тэнээлгэх тэнийлгэх; тэнийхийн үйлдүүлэх хэв
Тэнээх тэнийх; тэнэгэр болох
Тэнөөл тэнүүл; тэнэж явах, тэнэмэл
Тэнөөлч тэнүүлч; хэсүүлч, тэнэдэг зантай хүн
Тэнхээрхэх өвдөх, чилээрхэх
Тэнцөө тэнцүү; нэг адил, тоо тэнцүү

Тэнцөөлэх тэнцүүлэх; тэнцэхийн үйлдүүлэх хэв
Тэргөөн тэргүүн; толгой, толгой тэргүүн хоршсон үг
Тэрсөөд тэрсүүд; гажууд, зөрүүд; тэрсүүд зан гаргах
Тэсвэр үгээ тэсвэргүй; хүлцэл, хатуужил муутай
Тээхэн удам судар

У

Ув 1.мэхээрийг цэвэрлэж тосонд хийж холиход бэлэн болгохыг хэлнэ 2.хүч нэмэгдүүлэх чимэг үг
uwā ügē увай үгээ; аальгүй зантай, давамгай түрлүү
Угаагоор угаагуур; юм угаах зүйл
Угā гуай; хүнийг хүндэтгэн дуудсан үг
Угалзархоо угалзархуу; угалз мэт
Угжоолах угжуулах; угжихын үйлдүүлэх хэв
Угзроолах угзруулах; угзрахын үйлдүүлэх хэв
Угзчоолах байн байн угзчихын үйлдүүлэх хэв
Углоорга углуурга; хаалганы углуурга
Угсоорга угсуурга; эмээлийн олом, жирэм уях ширэн гогцоо.
Угтоол угтоол; 1.угтах хүн 2.амлан авах
Удрах бөс даавуу зүйлийг ханзлах
Улаандоо улаандуу; улаавтар өнгөтэй
Улас 1.улс төр, улс гүрэн 2.хүмүүс 3.үсийг нь зулмалсан зүр буга
Улээрэх улайрах; махрах, мэрийх, чармайх
Улээроолах улайруулах; улайрахын үйлдүүлэх хэв
Улээсах улайсах; галд халж улаан болох
Улээсгах галд халж улаан болох
Улээх 1.улаан болох 2.мэрийх, чармайх
Улажлоолах уламжлуулах; залгамжлах, өвлөхийн үйлдүүлэх хэв
Улироолах улируулах; улирахын үйлдүүлэх хэв
Улцээх улцайх; 1.нүд улцгар болох 2.бие сулрах
Умших унших; ном бичгийг унших
Унаажоолах унаажуулах; унаатай болохын үйлдүүлэх хэв
Унгатгах гал асаах, унгасгах уугиулах
Ундаасах цангах, юм уухыг хүсэх
Ундооцах унтууцах; баахан уурлах, бачимдах
Унжоо унжуу; доош унжсан, хэтэрхий дор болсон
Униа унь; гэрийн хананы дээр бөгсийг нь тогтоон бэхэлж , тоононы зүг бүрээс, үзүүрийн углуургаар

тогтоох урт урт мод

Унжоорго унжуурга; унжиж байх зүйл
Уноолах унуулах; унахын үйлдүүлэх хэв
Унооль унанги; унууль мод (унасан мод)
Унтоо унтуу; 1.уур унтуу 2.сэргэг цовоо биш
Унтоолах унтуулах; нойрсохын үйлдүүлэх хэв
Уншоолах уншуулах; ном бичгийг унших үйлийн үйлдүүлэх хэв
Урагсах элгэмсэх: ураг төрлөө гэдэг
Урал уруул; хүн амьтны амны хамхих хэсэг
Уралдоолах уралдуулах; хоорондоо хурд хүчээ сорихын үйлдүүлэх хэв
Урамшоолах урамшуулах; урамтай болохын үйлдүүлэх хэв
Урвоолах урвуулах; өөрийн гэр орноосоо зайлж өөр айлын хүн болохын үйлдүүлэх хэв
Урдоор урдуур; урд талаар, өмнүүр
Урих урхи; амьтныг оосорлон барих, чангарах гогцоо бүхий оосор
Уроо уруу; дээрээс доошоо
Уроодах уруудах; доошоо явах
Уроодоолах уруудуулах; уруудахын үйлдүүлэх хэв
Уртасгоолах уртасгуулах; урт болгохын үйлдүүлэх хэв
Урчууд урчууд; олон уран хүн
Уршаг уршиг; гай чирэгдэл болох
Усархоо усархуу; усархаг, ус мэт
Усжоолах усжуулах; устай болохын үйлдүүлэх хэв
Услоор услуур; усалдаг хэрэгсэл
Устгоолах устгуулах; устгахын үйлдүүлэх хэв
Утганцаг модны хожуул, ёзоор
Утгоор утгуур; утгах хэрэгсэл
Утоор утуур; утах хэрэгсэл
Уудих уйдах; уйтгарлах
Уулиа уйлаа; уйламтгай
Уулиан уйлаан; уйлаан майлаан
Ухроолах ухруулах; гэдрэг явахын үйлдүүлэх хэв
Ухоолагч ухуулагч; ухуулах, сэнхрүүлэх үйлийг гүйцэтгэгч
Ухоолах ухуулах; ухах үйлийн үйлдүүлэх хэв
Ухоолга ухуулга; ухуулах үйлийн нэр
Учар учир; шалтгаан
Учиг 1.юм оёж байсан зүүнд сүвлээтэй байгаа утас 2.төлөөр нь ивэлгээд бага зэрэг саах үйл

Учирлоолах учирлуулах; учирлахын үйлдүүлэх хэв
Уялцоолах уялцуулах; уяхын үйлдүүлэх хэв
Уянгалоолах унгалуулах; уянгалахын үйлдүүлэх хэв

Ү

Үгдрэх өвчин хүндрэх
Үглөөлэх үглүүлэх; үглэхийн үйлдүүлэх хэв
Үгөөлбэр өгүүлбэр
Үгөөллэг өгүүллэг
Үгөөлэх өгүүлэх; ярих
Үгөөлэхүүн өгүүлэхүүн
Үгтрэх үс унах
Үгтээх зулгаах, чангаах
Үгээ үгүй; бий гэдгийн эсрэг үг
Үгээлэх үгүйлэх; үгүй болсныг мэдэх
Үгээрөөлэх үгүйрүүлэх; үгүйрэхийн үйлдүүлэх хэв
Үгээрэл үгүйрэл; үгүйрэх үйлийн нэр
Үгээрэх үгүйрэх; хоосрох, барагдах
Үгээсгэл үгүйсгэл; үгүйсгэх үйлийн нэр
Үгээсгэх үгүйсгэх; бий бүхий юм, чухал зүйлийг үгүйд үзэх
Үдээр үдээс; гутлын үдээс
Үедэх хүн мал бороонд осгож даарах
Үзөөлэгч үзүүлэгч; 1.юмыг удирдан хянаж үзүүлэх хүн 2.ямар нэг баримт юм үзүүлсэн этгээд
Үзөөлэлт үзүүлэлт; үзүүлэх юм, харьцуулсан үзүүлэлт
Үзөөлэн үзүүлэн; хичээл заах, ухуулга таниулга хийхэд хэрэглэх зүйл
Үзөөлэх үзүүлэх; үзэх үйлийн үйлдүүлэх хэв
Үзөөр үзүүр; нарийн гонзгор юмны шовх нарийн тал
Үзөөр үгээ үзүүргүй; үзүүр байхгүй
Үзөөрлөөлэх үзүүрлүүлэх; үзүүрлэх үйлийн үйлдүүлэх хэв
Үзөөрсэг үзүүрсэг; уртын ноосыг хярган авсны дараа хонины үс нь ургаж, хайчилсан ором нь арилсан
Үзөөрт үзүүрт; үзүүрт бий
Үзөөртэй үзүүртэй; үзүүр бүхий
Үзөөштэй үзүүштэй; үзмээр, үзвэл зохих
Үжег цүнх шиг үүргэвчтэй арьсаар хийсэн сав
Үлтгэр урагдаж сэмрэх, муудах
Үлөөдэх илүүдэх; хэмжээнээсээ томдсон

Үлөөчлэх илүүчлэх; илүү гаргаж өгөх
Үмбөө үмбүү; бяцхан хүүхэд үхрийг нэрлэх үг
Үнэмшөөлэх үнэмшүүлэх; үнэн гэж итгүүлэхийн үйлдүүлэх хэв
Үнэрлөөлэх үнэрлүүлэх; үнэрлэхийн үйлдүүлэх хэв
Үнэртөөлэх үнэртүүлэх; үнэр сэрэгдэхийн үйлдүүлэх хэв
Үнэрхөө үнэрхүү; үнэрхэг, тунирхаг, тунирхуу
Үнэрхөөлэх үнэрхүүлэх; үнэрхэхийн үйлдүүлэх хэв
Үргэлжлөөлэх үргэлжлүүлэх; үргэлжлэхийн үйлдүүлэх хэв
Үргээ үргэмтгий; морь малын үргэдэг зан
Үржөөлэг үржүүлэг; үржүүлж олон болгох үйлийн нэр
Үрчээ жижиг хүүхдийг өхөөрдөн нэрлэсэн нэр
Үүл үйл; 1. хийх хэрэг явдал 2.оёх урлах зүйл 3.зовлон
Үүлчин үйлчин; оёх урлахад сайн хүн
Үүмрэх уймрах; ухаан санаа нь балартах
Үүмүүлэх үймүүлэх; сахилгагүйтэх
Үүмээн үймээн; 1.үймсэн 2.дайн дажин
Үүц хавар идэхээр бэлтгэсэн мах
Үхэг бөөв

Х

Хаац гэр орон гэдгийн доорд утга
Хабтас хавтас; ном зэргийн гадна тал
Хабтага хавтага; тамхины уут сав
Хагсах 1.аливаа нойтон зүйл хатах 2.модон хувин зэрэг зүйл хатаж шингэн зүйл хийх боломжгүй болох
Хадаржаан аливаа зүйлд гамгүй тухайлбал гутлаа байнга урдаг хүүхдийг- гутлын хар хадаржаан гэж загнах
Хадоон хадуун; бүдөөн хадоон- бүдүүн хадуун
Хадоор хадуур; өвс тариаг хадах зэвсэг
Хадоорах хадуурах; давхиж яваа морьны ам дийлдэхгүй буруу тийш зулран одох
Хажаас хажлага; дээлийн хажлага
Хажаг хажиг; зожиг
Хажоо хажуу; аливаа юмны нэгэн тал хажуу
Хажоодхан хажуудхан; хажууд ойрхон
Хажоолах хажуулах; 1.хажуугаараа хэвтэх 2.бяцхан зуур хэвтэж амрах
Хазавч хатавч; гэрийн хаалганы хоёр тал
Хазгайдоо хазгайдуу; баахан хазгай хэвгий

Хазоолах хазуулах; шүдээр зууж хазахын үйлдүлэх хэв
хăŋуă хайнга; хичээнгүй биш
хărăх хайрах; 1.морь мал хөлөөрөө өшиглөх 2.халуун зүйлээр хайрах 3.хүйтэн зүйлээс хайрах
Халим тогооны таг
Халоон халуун; илч дулаан
Халоорах халуурах; өвчний улмаас биеийн ердийн халуун нэмэгдэх
Халооцах халууцах; орчны нөлөөллөөс болж бие халууцан эвгүйцэх
Хамагч бярууг эхэд нь хөхүүлэхгүйн тулд хамарт нь зүүдэг модоор хийсэн зүйл
Хамоо хамуу; маш их загатнадаг арьсны халдварт өвчин
Хамхоол хамхуул; ургамал- талд ургах бөгөөд хатахдаа үндэснээсээ салан, бөөрөнхий бут болж салхинд хол газар бөмбөрөн хийсэх өвс
Хандоолах хандуулах; нэг зүгрүү чиглэхийн үйлдүүлэх хэв
Ханцээ ханцуй; дээл хувцасны гарт өмсөх хэсэг
Харанкээ харанхуй;гэрэлгүй, гэгээн биш
Харвагдах хамаг эрчээрээ гүйх
Харилцоор харилцуур; харилцах хэрэгсэл
Харио хариу; 1.асуусанд хэлэх үг 2.юмны ор хариулал буцаж ирэх үр дүн
Хармиэл карамель чихэр гэсэн харь үг
Хароо харуу; мөсөн дээгүүр явахад халтирахгүйн тулд асгасан шороон зам
Хароол харуул; 1.манаа манаж харгалзах этгээд 2.модыг харуулдан засах багаж
Хароолах харуулах; харахын үйлдүүлэх хэв
Хароолдах харуулдах; 1.ирэхийг горилон харж хүлээх 2.харуулаар өөлөх засах 3.түрүүлгээ харж таварцаглан унах
Харсункаараа хамгийн хурднаараа гүйх, давхих
Хатоо хатуу; 1.зөөлөн гэдгийн эсрэг утга 2.хахуун гашуун, чанга амттай 3.чанга шийдэмгий 4.хэцүү бэрх
Хатоовтар хатуувтар; баахан хатуу
Хатоожил хатуужил; тэсвэр
Хатоожил үгээ хатуужил үгүй; зориг тэсвэргүй
Хатоожих хатуужих; тэсвэртэй болох
Хатоожоолах хатуужуулах; хатуужихын үйлдүүлэх хэв

Хатоорах хатуурах; хатуу болох
Хатоорхоо хатуурхуу; баахан хатуу
Хахооль хахууль; өөрийн хэргийг биелүүлэхийн тулд эрх бүхий хүнд ил далд аргадан өгөх мөнгө буюу эд
Хацоор гацуур; мод
Хийдэмдэх хийх зүйлгүй нааш цааш холхих
Хий ухаар хий хуар
Хиргисөөр хиргисүүр; эрт дээр цагт ихэс дээдсийг оршуулсан булш
Хиртөөлэх хиртүүлэх; хир буртаг болохын үйлдүүлэх хэв
Хирээ 1.хөвөө 2.хөрөө (огтлох зүсэх багаж)
Хирэм 1.морины уяаны шонгийн хооронд татаж уясан сур 2.өмдний хирэм-өмдний тэлээ
Ховаа ховоо; ус татах хэрэгсэл
Ховсрох ая тал засах
Хогжроо хогжруу; арьсны эвэрлэг эс тослог хоёроос бүтсэн жижиг бужигнасан зүйл
Ходаад ходоод; эрхтэн
Хоё хөөе; хүүе гэсэн утгатай аялга, Аа хоё найзаа- хөөе найзаа
Хоёол хоёулаа
Хоёрдоолах хоёрдуулах; 1.сэтгэл санаа нэгэн чигт тогтворгүй байх 2.аливаа үйл ажлыг хоёрдуулах
Хожоо хожуу; сүүлд
Хожоол хожуул; газарт үлдсэн модны уг
Холбаа холбоо;1.юмыг хооронд нь холбосон зүйл 2.харилцан хэлхээ холбоотой байх
Холбаас холбоос; холбосон юм
Холбоолах холбуулах; холбохын үйлдүүлэх хэв
Холгоолах холгуулах; холгохын үйлдүүлэх хэв
Холдоолах холдуулах; холдохын үйлдүүлэх хэв
Холилдоолах холилдуулах; холилдохын үйлдүүлэх хэв
Холхиндог гутлыг оймсгүй өмсөх
Холцроо холцруу; арьсны өнгө хөрсөнд осгоруутан тогтсон бэржгэр
Холшаах холшоох; хол гэж үзэх
Хонжаа хонжоо; ашиг
Хонтоор контор харь хэлний үг
Хонтоорлах контортоо сууж ажиллах
Хоноолах хонуулах; хонох үйлийн үйлдүүлэх хэв
Хоо хуу 1.шингэн юм агуулах данх сав 2.нэгмөсөн дуустал

Хоовгоно нэг төрлийн дэнгийн эрвээхэй
Хоодас хуудас; 1.хуучирч муудсан даавууны хэсэг 2.номын хуудас 3.далны хуудас
Хоолах хуулах; юмыг буулгаж бичих
Хоолбар хуулбар; хуулж буулгасан юм
Хооллоолах хооллуулах; хооллох үйлийн үйлдүүлэх хэв
Хоолоолах хуулуулах; хуулах үйлийн үйлдүүлэх хэв
Хооль хууль; 1.тогтмол зүйн дотор илэрч гарах жинхэнэ үнэн байдлын аливаа үзэгдлүүдийн хоорондын холбоо ба харьцах зүй тогтол 2.засгийн дээд эрхийг барих газраас дагаж мөрдөхөөр баталсан тогтоол
Хоольч хуульч; хуулийн мэргэжилтэн
Хоор хуур; 1.хөгжмийн зэмсэг 2.хуурч мэхлэх
Хоорай хуурай; 1.нойтон гэдгийн эсрэг утга 2.төмөрлөгийн зүйлийг үрж хавиран хурцлах багаж
Хоорайдах хуурайдах; хуурайгаар үрэх
Хоорайлах хуурайлах; норсон нойтон зүйлийг хуурай з үйлээр солих
Хоорамч үнэн бодтой биш
Хоорах хуурах; 1.арьс, хальс зэргийн юм өөрөө хууран салах 2.оргүй зүйлийг зохиож хэлэлцэх 3.хоол идээний зүйлийг халуунд хайрч болгох
Хоорга хуурга; ногоо мах зэрэг идэшний зүйлийг хэрчин жижиглэж, тостой хутган хайрч болгосон идээ
Хоордах хуурдах; хуур хөгжмөөр хөгжимдөх
Хоошоор хуушуур; мах татаж, ногоо давс холин гурилд хучиж, хавтгайлан хайрч болгосон идээ
Хораах хороох; цөөрөх багасах
Хорхээ хорхой; олон эст амьтны аймагт багтах сээргүй амьтад
Хоршаа хоршоо; 1.санал хүчээ нэгдэн хавсарч эд хөрөнгөөр буюу биеийн хүчийг хамтруулан байгуулсан нэгдэл 2.дэлгүүр хоршоо
Хослоолах хослуулах; юмыг ижил хос болгохын үйлдүүлэх хэв
Хотлоолах хотлуулах; мал тэжээврийн хот хэвтэшдээ орох үйлийн үйлдүүлэх хэв
Хошлан монгол гэрийн бүслүүр
Хошгиног хошного
Хошоо хошуу; 1.хүн амьтны хамрын үзүүрийн тус газар 2.юмны шувтайж барагдсан үзүүр этгээд

3.засаг захиргааны нэгж

Хошоолдах хошуулдах; хошуу болгох, хошуу гаргах

Хошоорах хошуурах; амьтан хүний ямар нэгэн зүйлрүү зүтгэн тэмүүлэх

Хошооч хошууч; 1.хамгийн түрүүнд явагч 2.цэргийн албан хаагчид олгох нэг төрлийн цол

Хоэвалдаан хуйвалдаан; нууц сүлбээ

Хоэгоор хойгуур; хойд талаар

Хоэмар хоймор; гэрийн доторх тулганаас хойших зай

Хоэна хойно; умард зүг

Хөвээ хөвөө; 1.эд юмны амсар зах ирмэгийг мөшгөөрлөн тавьсан эмжээр 2.юмны хоёр зах хажуу 3.хөгшин хөвөө

Хөвээлэх хөвөөлэх; 1.юмны хөвөөгөөр явах 2.юманд хөвөө хийх

Хөгжөн хөгжөөн; наргиан зугаа

Хөгжөөлэх хөгжүүлэх; бадрах дэвжих үйлийн үйлдүүлэх хэв

Хөдөлгээн хөдөлгөөн; 1.материйн оршин ахуйн хэлбэр 2.нийгмийн тодорхой санал зорилго бүхий үйл явдал

Хөдөлгөөр хөдөлгүүр; аливаа ямар нэгэн зүйлийг хөдөлгөдөг хүчин зүйл

Хөдээ хөдөө; 1.аглаг хээр газар 2.хөдөө орон нутаг

Хөдээлэх хөдөөлөх; хот суурин газраас хөдөө гарах

Хөзөрдөөлэх хөзөрдүүлэх; хөзрөөр наадахын үйлдүүлэх хэв

Хөлсөх 1.онгирох 2.хүний бие голдуу хүүхэд багачуудын бие гаднын хөл үймээнээс шалтгаалж ая тавгүй болж өвдөх, их хэмжээгээр халуурах

Хөлчөө хөлчүү; согтуу

Хөмөөжигч хүмүүжигч; хүмүүжигч

Хөмөөжил хүмүүжил; нийгмийн амьдралд илрэх зан чанар

Хөмөөжил үгээ хүмүүжилгүй; хүмүүжиж чадаагүй

Хөмөөжөөлэгч хүмүүжүүлэгч; бусдыг удирдан залж ,зөв сайны зүг хандуулах буюу асран харгалзах хүн

Хөмхээ уруулын доод талын хэсгийг шүдээрээ хазах, хөмхээ зуух

Хөнгөндөө хөнгөндүү; баахан хөнгөн шингэн

Хөнгөрөх төрөх; бие давхар эмэгтэй төрөх

Хөндөөр хөндүүр; бие махбодын өвчин эвэршил бүхий эмээг бөгөөд хүрэлцвэл хөндөгдөх хэсэг

Хөндөөрлэх хөндүүрлэх; хөндүүр өвчин бүхий газар

Хөнөг хувин; шингэн зүйлийг агуулах нэгэн зүйлийн сав

Хөнээл хөнөөл; хөнөөх үйлийн нэр

Хөө 1.эрэгтэй хүүхэд 2.юманд тогтсон утаа тортог 3.уршиг балаг 4.мөнгөний хүү

Хөөргөн онгиргон сагсуу

Хөөрөөлэх хөөрүүлэх; сүү хөөрүүлэх

Хөөрхөх гайхуулах

Хөөс хөөс; хүйс; 1.шингэн юмны дотоодод хий орж цэврүүтэн хөвсөн юм 2.амьтны эхээс төрөхдөө ихэстэй холбоотой гардаг судал 3.хүн адгуус амьтны эр эм

Хөөсрөөлэх хөөсрүүлэх; хөөс тогтоох үйлийн үйлдүүлэх хэв

Хөөтэн хүйтэн; халуун гэдгийн эсрэг утга

Хөөтрэх хүйтрэх; цаг улирлын уур амьсгал хүйтэн болж хувирах

Хөөхэд хүүхэн; нас биед хүрсэн эмэгтэй

Хөрээ хөрөө; огтлох зүсэх багаж

Хөрээдэх хөрөөдөх; юмыг огтлох зүсэх

Хөтөвч шээх сав

Хөх зөндөө зүв зүгээр

Хөхөөр хөхүүр айраг тараг шингэн зүйлийг хийхийн тулд шир, хөм зэргээр хийсэн сав

Хөцөөрөх загнах, зэмлэх

Хөшээ хөшөө; ямар нэгэн тэмдэг дурсгал болгон босгосон зүйл

Хөшөөн хөшүүн; зан ааль нь элдэг биш

Хөшөөрдэх хөшүүрдэх; юмыг хөшүүрээр хөшиж өргөх

Хөшөөрэг хөшүүрэг; юмыг өргөх татах зэрэгт хэрэглэх зүйл

Хөшөөрэгдэх хөшүүрэгдэх; хөшүүргээр хөшиж өргөх

Хубтас хувцас

Хулдай хулдаас; элдэв эдлэл хэрэглэлийг өнгөлөн бүрхэх хулдахад зориулсан эд, шалны хулдаас

Хулчээх хулчийх; халирах, зориглохгүй байх

Хумас хумс; хүн амьтны хөл гарын хуруунд байх хатуу эвэрлэг зүйл

Хунх халби цахиур бууны гох чангалдаг зүйл

Хунш хүний ханилгааны чанар

Хураагоор хураагуур; аливаа юмыг хураах хэрэгсэл

Хурамш утаанд идэгдсэн эсгий

Хурд хуруул; хэвлэн тавьсан том ааруул

Хуроо хуруу; хүн амтьны гар хөлийн сарвуунууд
Хуроовч хуруувч; юм оёход жийрэглэн түлхэх хэрэгсэл
Хуроодах хуруудах; хуруу гарган наадах
Хусоор хусуур; хусах хэрэгсэл
Хусоордах хусуурдах;хусуураар хусах
Хуцоолах хуцуулах; хуцах үйлийн үйлдүүлэх хэв
Хучоолах хучуулах; хучихын үйлдүүлэх хэв
Хувэрхээ хувэрхий; юмны уяа зангилааг татах, тайлахад хялбархан алдрахаар уясан уяа
Хүгдгэр нуруугаараа яльгүй бөгтөр
Хүгдээх хүгдийх; хүн амьтны нуруу цээжин бие хэвийн жишгээс бөгтөр хүгдгэр болох
Хүзөө хүзүү; 1.хүн амьтны толгой сээр хоёрын дунд залгалдан орших хэсэг 2.савны амсар талын буюу өөр зарим нэгэн юмны нарийн шувтан хэсэг
Хүзөөвч хүзүүвч; 1.амьтны хүзүүнд уях торгох буюу тэмдэг чимэг болгож зүүсэн зүйл 2.уул хярын үзүүр шувтрагын ойр бүхий бяцхан хөтөл онь 3.хоёр юмны хооронд холбосон нарийн зурвас юм
Хүзөөвчлэх хүзүүвчлэх; хүзүүвч хийх
Хүзөөдэх хүзүүдэх; хүзүүгээр тэврэх
Хүмөөс хүмүүс; олон хүн
Хүндрөөлэх хүндрүүлэх; хүндрэхмйн үйлдүүлэх хэв
Хүнсжөөлэх хүнсжүүлэх; хүнстэй болгохын үйлдүүлэх хэв
Хүнкээх хүнхийх; хонхор хүнхэр болох
Хүнкрээ хүнхрээ; үнээний сүүлийн самсааны хоёр этгээд дэх хөвчилсөн булчин мах
Хүнкэр хүнхэр; хонхор болсон
Хүрздөөлэх хүрздүүлэх; хүрздэхийн үйлдүүлэх хэв
Хүрэндөө хүрэндүү; хүрэвтэр өнгөтэй
Хүүрхэх морь мал омгорхох, ямар нэгэн зүйлээс жигшин ааш авир нь догшрох, сарлаг нохойноос хүүрхэх-сарлаг нохойноос жигших
Хэвлөөлэх хэвлүүлэх; юмыг хэвд дарахын үйлдүүлэх хэв
Хэвлөөн хэвлүүн; хэвийн жишээнээс хэтэрхий ихэмсэг ааль авиртай
Хэвтөөлэх хэвтүүлэх; хэвтэхийн үйлдүүлэх хэв
Хэгжөөн хэгжүүн; зөв бурууг ялгахгүй, хэдэр хөшүүн байлаар зөрчих, гөжүүрхэх буюу үл тоомсорлох ааль авир

Хэгэх хэрчих, жижиглэх
Хэлөөлэх хэлүүлэх; хэлэх үйлийн үйлдүүлэх хэв
Хэмжүүр хэмжүүр; аливаа зүйлийн жинг хэмжих багаж
Хэрсөө хэрсүү; үйл явдалд хашир хянамгай
Хэрөөл хэрүүл; 1.хүмүүс санаа тохирохгүй харилцан тэмцэж цуугих 2.тарвага агнахад хэрэглэдэг даллуур
Хэрөөлч хэрүүлч; хэрүүлд дуртай
Хэрцгээ хэрцгий; зан ааль хэдэр
Хэрчлээ нэг төрлийн хэрчиж хийсэн боорцог (самнаа)
Хэцөө хэцүү; сүрхий бэрх хүнд
Хэцөөдөөлэх хэцүүдүүлэх; хэтэрхий хэцүүдэхийн үйлдүүлэх хэв
Хээнцэглэх бөс даавууг багасган буруу эсгэж , хэрэгцээгүй болгох
Хяноолах хянуулах; хянахын үйлдүүлэх хэв
Хярмац хярамцаг; өвлийн идэшний бог малын гэдэс дотрыг гүзээнд нь хийж хөлдөөсөн нөөц
Хяргоолах хяргуулах; малын үс ноосыг хайч мэтийн зэвсгээр огтолж авахын үйлдүүлэх хэв
Хяроо хяруу; газарт бууж тогтсон шүүдрийн хүйтэнд царцсан цан
Хярлайх хэтэрхий ядарсан цонхигор царай

Ц

Цаа цаа буга, бугын төрлийн нэгэн зүйл гэрийн тэжээмэл амьтан, хөвсгөлчүүдийн зургаан хошуу малын нэг
tsā цай; хандалж уудаг нэг зүйл ургамлаар хийсэн ундаа
Цабчих цавчих; иртэй зүйлээр ямар нэгэн зүйлийг хэсэглэх
Цаагоор цаагуур; холуур
Цааараг хадуурын багли
Цаарс цаас; бичиг бичих, хэвлэх, зурах болон хулдах зэрэг зүйлд хэрэглэх зорилгоор хийсэн эдлэл
Цаашлоолах цаашлуулах; улам цааш болохын үйлдүүлэх хэв
Цавоо цавуу; нааж наалдуулахад хэрэглэх юм
Цавоодах цавуудах; юманд цавуу түрхэж наалдуулах
Цабчир дүнз модыг цавчихад гарсан түлэхэд зориулсан зүйл
Цагцаахай бүргэдийн зулзага
Цадаарах 1.эд хөрөнгөндөө бардамнаж сагах, сагсуурах 2.төл мал сүүндээ гүйцэд цадах
Цалам сур дээсний нэгэн үзүүрт гогцоо гаргаж , нөгөө

талыг оруулан эвхэж эргүүлэн хаяж адуу малын толгойгоор оосорлон барих хэрэгсэл бугуйл ч гэдэг

Цамаандоо цамаандуу; цамаан зан байдалтай

Цамхраа тоононд байдаг

Цанаг чарга; хүн өөрөө чирч явах бага оврын чарга

Цардаг цатгалан; уяа сойлгогүй морь мал

Царигтай настай хүнийг тэнхлүүн байна гэсэн утгатай үг

Царцаахай царцаа

Царцоо царцуу; халуун бүлээн биш, царцуу өөх

Цахиор цахиур; гал гардаг нэгэн зүйл хатуу чулуу

Цовхчоолах цовхчуулах; байн байн цовхрохын үйлдүүлэх хэв

Цогилог хорол биш тоононы голд байх дөрвөлжин нүх зай

Цогцгой модны борогцой

Цогцлоолах цогцлуулах; юмыг зэрэгцүүлж давхцуулан өрж, дэгжүүлэн хураах, босгох бүтээх үйлийн үйлдүүлэх хэв

Цогшоолах цогшуулах; галын дөл утаа барагдаж улаан цог нь үлдэн цогших үйлийн үйлдүүлэх хэв

Цоллоолах цоллуулах; хүчит бөх, хурдан морь зэрэгт олгосон цолыг олны дунд өндөр дуугаар хэлэх цоллох үйлийн үйлдүүлэх хэв

Цоолтоор цоолтуур; цоолж нүхлэх багаж

Цоолтоордах цоолтуурдах; цоолтуураар цохиж цоолох

Цоолоолах цоолуулах; юманд нүх сүв гаргахын үйлдүүлэх хэв

Цохдоолах цохдуулах; цохон дээр нь няслах үйлийн үйлдүүлэх хэв

Цохоолах цохуулах; аливаа бичиг хэрэгт, удирдах хүмүүсээс хэрхэн гүйцэтгэвэл зохих тухай заасан цохох үйлийн үйлдүүлэх хэв

Цочирдоолах цочирдуулах; хэтэрхий цочир болох үйлийн үйлдүүлэх хэв

Цочмогдоо цочмогдуу; цочмог зан байдалтай

Цөөдөөлэх цөөдүүлэх; хэтэрхий цөөн болох цөөдөх үйлийн үйлдүүлэх хэв

Цөөрөөлэх цөөрүүлэх; цөөн болох үйлийн үйлдүүлэх хэв

Цөрөм цөрөм; нимгэн зүсэж хатаасан ааруул

Цөцгэй цөцгий; сүүний дээгүүр өрөмтсөн тослогийн хувь

Цувоолах цувуулах; цувах үйлийн үйлдүүлэх хэв

Цугаараа бүгдээрээ

Цуглоолагч цуглуулагч; хүн амьтан,эд юмны нэгэн газарт олноор хурах , цугларах үйлийг гүйцэтгэгч

Цуглоолах цуглуулах; цуглах үйлийн үйлдүүлэх хэв

Цуглоолга цуглуулга; цугласан юм

Цулбоор цулбуур; морь малыг хөтлөх уяхад зориулан хазаар ногтод байдаг сур

Цулбоордах цулбуурдах; морины хазаарын цулбуураас барих

Цуслах идэх гэдгийн доорд утга хараалд хэрэглэдэг

Цутгоор цутгуур; юм цутгадаг хэв

Цуйгаан(цоэгаан) хэрүүл цуугиан

Цуйдар юмнаас цуулж авсан хэсэг

Цэврөө цэврүү; түлэгдэх, холгох, хөлдөх зэрэг шалтгаанаас арьсанд бий болох устай гүвдрүү

Цэврөөтэх цэврүүтэх; цэврүү үүсэх

Цэвэрлөөлэх цэвэрлүүлэх; цэвэр ариун болгох үйлийн үйлдүүлэх хэв

Цэглөөлэх цэглүүлэх; цэг тавих, цэгтэй болгох үйлийн үйлдүүлэх хэв

Цэгнөөлэх цэгнүүлэх; цэгнүүр хэмжүүрээр хэмжих үйлийн үйлдүүлэх хэв

Цэгцлөөлэх цэгцлүүлэх; юмыг цэгцтэй журамтай болгох үйлийн үйлдүүлэх хэв

Цэрвөө цэрвүү; юманд халдан ойртож чадахгүй холхон буюу дөнгөж хүрэлцэх төдий байх

Цэрцээ цаа, гөрөөс зэрэг амьтны хөлийн дээд талд буюу бэрэвхий орчимд байх хос зүйл

Цэрэг цэрэг; 1.морийг уях шон 2.улсын зэвсэгт хүчин

Цэцэглөөлэх цэцэглүүлэх; цэцэглэхийн үйлдүүлэх хэв

Цээжлөөлэх цээжлүүлэх; ном бичгийг цээжиндээ тогтоох үйлийн үйлдүүлэх хэв

Цээрлөөлэх цээрлүүлэх; цээр хориг тавихын үйлдүүлэх хэв

Ч

Чааараг 1.чийрэг 2.бөх бат чанартай чааараг даавуу

Чавдоо чадваг; ховор цэвэр

Чагнаал сигнал; сонсох дохио гэсэн харь үг

Чагноор чагнуур; чагнах хэрэгсэл

Чагтага монгол гэрийн тоононы голоос уях оосор

Чагтагалах 1. тоононы чагтаганаас хүнд юм уяж чагтага авах 2.саад тотгор хийх

Чадваржоолах чадваржуулах; чадвар дадалтай болохын үйлдүүлэх хэв

Чандроо чандруу; галаас гарах үнс мэт жижиг зүйл
Чарӑдах ууртай байх, зан муутай байх
Чарга цас мөсөн дээгүүр морь малын тусламжтайгаар чирч явах хэрэгсэл
Чардӑх маш их хичээнгүйлэн зүтгэх
Чарлоолах чарлуулах; бахирч орилох үйлийн үйлдүүлэх хэв
Чацархоо чацархуу; чац бие томтой
Чацоо чацуу; 1.адил хэмжээтэй зүйл 2.бие, нас чацуу
Чацоолах чацуулах; юмны урт өргөн нарийн зэргийг зэргэцүүлэн адилтгаж үзэх
Чацоорхах чацуурхах; чацуу үе тэнгийн гэж найзархах
Чигжөө чигжүү; шигүү нягт болох
Чигжөөдэх чигжүүдэх; хэтэрхий чигжүү болох
Чигжээс хөдөлж холхихгүйгээр чигжих юм
Чиглөөлэх чиглүүлэх; зүглэх чиглэх үйлийн үйлдүүлэх хэв
Чигчлөөр чигчлүүр; хүний шүдний завсар орсон юмыг арилгах ухуур
Чийлэрхээ тайлагдахааргүй уясан, хөвөрхий гэдэгтэй эсрэг утгатай
Чилээрхөө чилээрхүү; хүндэтгэвэл зохих хүний бие лагшин өвдсөнийг хэлэх
Чимхлөөр чимхлүүр; жижиг сажиг ажиллагаа төвөг ихтэй няхуур ажил
Чимхөөр чимхүүр; юмыг хавчих чимхэх хэрэгсэл
Чимэглөөлэх чимэглүүлэх; чимэх гоёх үйлийн үйлдүүлэх хэв
Чиргөөл чиргүүл; чирч явахад тохируулж хийсэн зүйл
Чиргөөлдэх чиргүүлдэх; чирэгдэж явах
Чисчөө чисчүү; нэгэн зүйлийн торгомсог даавуу
Чихдөөлэх чихдүүлэх; чихнээс нь барих татах үйлийн үйлдүүлэх хэв
Чихөөлэх чихүүлэх; аливаа зүйлд юмыг хүчээр багтаан хийх үйлийн үйлдүүлэх хэв
Чихчээ чигчий; хүний гар хөлийн хурууны хамгийн жижиг нь
Чихчээлэх чигчийлэх; шүдний завсар орсон юмыг чигчлүүрээр цэвэрлэх(угтаа чигчий хуруугаараа ухах гэсэн утгатай)
Чихцэлдэх хэтэрхий шахцалдах
Чихэлдэх хэтэрхий шахцалдах
Чичөөр чичүүр; хатгах чичих хэрэгсэл
Чолоо,чулоо чулуу; хэсэг хэсгээр буюу бөөн цулаар орших

чулуулаг
Чолоодах чулуудах; 1.чулуугаар шидэх 2.юмыг шидэх, ширүүн хаях
Чолоожих чулуужих; 1.ямар нэгэн юм чулуу мэт болон хатуурах 2.хэтэрхий чулуутай болох
Чохом чухам
Чөө Чой; хүний нэр
Чөөжил Чойжил; хүний нэр
Чөлээ чөлөө; 1.уужим зай талбай 2.зав зай
Чөлээлэх чөлөөлөх; 1.ажил үүргээс түр чөлөө өгөх 2.эрх чөлөөтэй болгох
Чөлээлөөлэх чөлөөлүүлэх; чөлөөлөхийн үйлдүүлэх хэв
Чулоорхаг чулуурхаг; чулуу ихтэй
Чунсал бөөгийн тахилга хийхэд хэрэглэдэг зүйл. Чунсалд; хонины өвчүүний бүдэрхий, богино хавирга, шагайт, уураг сүүл, сүр орно
Чоолган чуулган; ямар нэгэн хэрэг ажлыг зөвлөлдөхийн тулд олноороо хуран цугласан хурал

Ш

šāwā̆ ганган дэгжин галбир сайтай
Шаадам шийдэм; зодох жанчих хэрэгсэл
Шаадамдах шийдмээр цохих
Шаар шийр; дөрвөн хөлт амьтны нарийн шилбэ яс, таахайг арьстай нь авсан хэсэг
Шабдоо шавдуу; яаруу шамдуу
Шаваадас үхэр буханд гарсны тэмдэг
Шавхрага 1.шаар шавхруу 2.эмэгтэйчүүдээс хүүхэд төрсний дараа савнаас гарах зүйл
Шавхроо шавхруу; юмны үлдэгдэл
Шавхоордах шавхуурдах; нарийн урт зүйлээр ороолгон цохих
Шагээвэр шагайж харахад зориулсан нүх
Шагалцах шагайгаар наадах
Шагноолах шагнуулах; шагнахын үйлдүүлэх хэв
šadzā̆x шазайх, ярзайх; сөрвийх, дорсойх, дээвэр шазайх
Шазроо шазруун; омголон, долгин зантай
šā̆dz сойз; шүд угаахад зориулсан хэрэгсэл
šā̆dzdā̆x сойздох; сойзоор угаах
Шалан үхрийн омрууны дагуу дахь сул арьс

Шаргаах 1.байн байн юм асуух нэхэх 2.хариуцлага хүлээлгэх
Шарлоолах шарлуулах; 1.тос шарлуулах 2.шар өнгөтэй болгох
Шалгар 1.адууны доторх бүдүүн гэдэс 2. эргэн өмд
Шалдган шалдан; өмд өмсөөгүй
Шароос эсгийний найрт гаргах шүүс, зоог
Шахоо шахуу; 1.шахам 2.чигжүү болох
Шахоорга шахуурга; аливаа зүйлийг шахаж хавчихад зориулсан хэрэгсэл
Шивөөр шивүүр; юмыг шивж цоолох төмөрлөг багаж
Шивөөрдэх шивүүрдэх; шивүүрээр шивэх
Шивхрэх олон хүн амьтан цугларч үймэлдэж байгаад тарж цөөрөх
Шивэгнэлдэх шивнэлдэх; бусдад сонсогдохооргүй өөр хоорондоо ярилцах
Шивээхэй гутал зэргийг хаддаг жижиг хадаас
Шигөө шигүү; нягт зай багатай
Шидмэс шидэмс; хуучирч муудсан дээс
Шидэрхэх бөө нар хүч чадлаараа хоорондоо гайхуулах
Шийгэм – 1.ид дундаа 2.шийгэм галзуу – маш их хурц өвчлөлтэй галзуурсан хүн
Шийдэн чийдэн; гэрэл
Шилбөөр шилбүүр; амьтныг хөөж туухад хэрэглэх зэвсэг
Шилбөөрдэх шилбүүрдэх; шилбүүрээр шавхрах
Шилжөөлэг шилжүүлэг; шилжүүлэх үйлийн нэр
Шилмөөс шилмүүс; навчит бус модонд байдаг зүү хэлбэртэй ногоон цацаг
Шилөөс шилүүс; мийн язгуурын араатан амьтан
Шилэмдэх бөс даавууг шүлсээрээ чийглэн дэвтээж ором тэмдэг тавих
Шийс шээс
Шийх шээх
Шилжрээ бороо цас орсноос болж зам харгуй халтиргаа гулгаатай болох
Шилээвэр 1.гал хутгадаг төмөр 2.гал асаах, үлээх хэрэгсэл
Шимэлдэг нэг төрлийн ургамал
Шингэ шиг; шиг мэт
Ширвөөл ширвүүл; юм ширвэхэд зориулж хийсэн хэрэгсэл тухайлбал, тогоо, хог зэргийг шүүрдэх шүүр
Ширгэлэг хүүхдийн хөлсөөг гаргахад хэрэглэдэг бөөгийн ёс
Ширгэдэс үхрийн сүүгээр хийсэн нэг төрлийн аарц

Ширөөн ширүүн; 1.хатуу ширүүн зүйл, 2.хатуу ширүүн зан ааш
Ширөөсэх ширүүсэх; улмаар ширүүн болох
Шоогаан шуугиан;
Шолтронго дутуу бүрэлдсэн тараг
Шораа шороо; дэлхийн гадаргыг бий болгогч сэвсгэр бодис, газар шороо
Шормон гутал; гараар оёсон өдөр тутам өмсдөг гутал
Шохээ шохай; шохойн чулууг шатаан гарган авсан кальцийн исэл болох цагаан бодис
Шөөдөнг бага зэргийн нойтон түлээ мод
Шөрөг 1.гол төлөв дээд этгээдэд шовх үзүүр гарган хийсэн сараалж хашаа , хайс 2.эхэд нь хөхүүлэхгүйн тулд хоёр настай малын хамарт уяж торгох хэрэгсэл
Шубтадах зугатах, зайлах
Шувоо шувуу; бүлээн цуст сээр нуруутан амьтан, биедээ өд өрөвлөг жигүүртэй, өндгөөр үрждэг, зүйл ялгал маш олон
Шузага 1.морины уяа 2.юм өлгөх шон
Шулам 1.гай тотгор болох хий зүйл 2.адтай овсгоотой хүн
Шулах 1.зодох 2.махыг яснаас нь салган авах 3.дарлан мөлжих 4.бага үнээр бусдын эд зүйлийг авах
Шулоон шулуун; 1.муруй хазгайгүй тэгш
Шулоорах шулуурах; 1.шулуун болох 2.үйл явдал саад тотгоргүй болох
Шургоо шугуу; хичээл зүтгэл их, шургуу ажиллах
Шургоолга юм агуулах нүд татуур бүхий сав
Шуу тохойноос сарвуу хүртэл газар

Э

Эблэл эвлэл;
Эбчөө өвчүү; амьтны цээжний өвөр этгээдэд хавирганы бөгсний мөгөөрсөөр залгалдсан уртавтар хавтгай яс
Эбдрөөлэх эвдрүүлэх; юмны бүрэн бүтэн байдал алдагдах үйлийн үйлдүүлэх хэв
Эбдэрхээ эвдэрхий; бүрэн бүтэн алдагдаж эвдэрч хэмхэрсэн
Эблөөлэг эвлүүлэг; эвлүүлсэн юм
Эблөөлэгч эвлүүлэгч; эвлүүлэх үйл гүйцэтгэгч этгээд
Эблөөлэх эвлүүлэх; эд юмсын хоорондоо яв цав тохирох ,

нийлэх үйлийн үйлдүүлэх хэв

Эвхрөөлэх эвхрүүлэх; хүн амьтны бие агдайх эвхрэн хэвтэх үйлийн үйлдүүлэх хэв

Эгдөө эгдүү; 1.санаанд үл нийцэх зүйлийг жигших, голох 2.нялх амьтныг өхөөрдөх

Эгдөөтэй эгдүүтэй; эгдүү бүхий

Эгдөөцөөлэх эгдүүцүүлэх; эгдүүцэхийн үйлдүүлэх хэв

Эгшөөн эгшүүн; хуурай агшуун

Эдлөөлэх эдлүүлэх; аливаа эд юмсыг ашиглан хэрэглэх үйлийн үйлдүүлэх хэв

Эзтэй 1.албатай юм шиг 2.сайн биш

Эз дийлэх түрэмгийлэх, дайрах

Элбэгдөөлэх элбэгдүүлэх; юмны элбэг хүрэлцээтэй байхын үйлдүүлэх хэв

Элбэгжөөлэх элбэгжүүлэх; элбэг дэлбэг болохын үйлдүүлэх хэв

Элгээдмэр "элгээ идмэр"гэсэн хараал

Элдөөлэх элдүүлэх; элдэх үйлийн үйлдүүлэх хэв

Элдөөр элдэж байгаа зүйл

Элдөөрчин арьс боловсруулдаг хүн

Элмэг 1.эдэлгээнд сураагүй мал 2.юм үзэж нүд тайлаагүй

Элсөөлэх элсүүлэх; аливаа байгууллага, сургуульд сайн дурараа элсэх үйлийн үйлдүүлэх хэв

Элтлөөлэх элтлүүлэх; эмтрэх үйлийн үйлдүүлэх хэв

Элтээр урьд өмнө, хэдийнэ

Элтэрхээ аяга зэрэг зүйлийн хагарсан хэсэг зүйл

Элэглэх 1.хүүхэд багачуудын мөлхөж эхлэхийн урьд элгээр гулгалхийн явах ба, хүн элгээрээ гулгалхийлэн гэтэх буюу мяраах 2.тараг цагаан идээнд хүүхэд элэглэх 3.юмыг дууриан аашлах 3.бусдыг басамжлан доромжлох

Элээ элий; элий балай

Элээрэх элийрэх; элий балай болох

Эмжээрлөөлэх эмжээрлүүлэх; эд юмны зах сэжүүр зэрэгт мөшгөөр хийх үйлийн үйлдүүлэх хэв

Эмзэглөөлэх эмзэглүүлэх; өвчний хөндүүр эмзгийг хүлцэж чадахгүй эмзэглэх үйлийн үйлдүүлэх хэв

Эмнөөлэх эмнүүлэх; өвчнийг эмчлэн засах үйлийн үйлдүүлэх хэв

Эмсгээ эмсгий; эмсгэр, үүдэн шүд нь унаж онгойсон

Эмтэрхээ эмтэрхий; эд зүйлийн хэмхэрч эмтэрсэн

Эмхлөөлэх эмхлүүлэх; цэгцтэй болгох үйлийн үйлдүүлэх хэв

Эмтрөө 1.аягаы эмтрүү 2.хувцас хийхэд оруулсан зүйдэл

Эмчлөөлэгч эмчлүүлэгч; эмчлүүлэгч хүн

Эмчлөөлэх эмчлүүлэх; эмчлэхийн үйлдүүлэх хэв

Эндөө эндүү; андуу, буруу

Эндөөрэл эндүүрэл;

Энөөнээ үүний; үүнд харъяалагдахын заах төлөөний үг

Энөөхэн энүүхэн; энд маш ойрхон

Энкрээ энхрий; бусдаас илүү үлэмж хайрладаг

Энкрээлөөлэх энхрийлүүлэх; хайрлах энхрийлэх үйлийн үйлдүүлэх хэв

Энэхөө энэхүү; энэ, сая дурдсан буюу үзсэн сонссон, эсвэл нүдний өмнө байгаа эл юмыг заан хэлэлцэхэд хэрэглэх үг

Эргөө эргүү; 1.ухаан муутай 2.малд тохиолдох нэг төрлийн өвчин

Эргөөл эргүүл; хянах сэргийлэх буюу харж харгалзахын тулд эргэж хянах албан тушаалтан

Эргөөлэг эргүүлэг; эргэдэг юм 1.ус мөрний ойл усны эргүүлэг 2.хүн амьтны үсний ширхэг эргэн ургасан

Эргөөлэх эргүүлэх; эргэх тойрох үйлийн үйлдүүлэх хэв

Эргөөтөөлэх эргүүтүүлэх; 1.хүн амьтны ухаан бодол төөрөгдөн балартахын үйлдүүлэх хэв

Эргэлдөөлэх эргэлдүүлэх; эргэлдэхийн үйлдүүлэх хэв

Эргэнэг тогоо шанага, аяга таваг зэргийг агуулах сав

Эрдээ ерөөсөө

Эрийн хуйх сайн эр

Эрөө эрүү; 1.хүн амьтны толгойн амнаас дооших хэсэг 2.зуухны аман этгээдэд гал үнс зэргийг тосч байрлуулах зүйл 3.гэмт хэрэг үйлдэгчдийг залхаах эрүү цааз

Эрөөвч эрүүвч; ногт хазаарын сагалдрага

Эрөөвчлэх малгайн чихийг эрүүн доогууруа татаж уях

Эрөөдэх эрүүдэх; эрүү шүүлт тулган хүлээлгэх

Эрөөл эрүүл; өвчин эмгэггүй эсэн мэнд

Эрөөлжих эрүүлжих; эрүүл болох

Эрөөлжөөлэх эрүүлжүүлэх; 1.өвчин зовлонгүй эрүүл саруул болохын үйлдүүлэх хэв 2.архидан согтуурсан хүнийг эрүүл болгох

Эрхэх 1.ааль ааш муутай 2.зарим өвчний үед хүндрэх, хөх өвдөх (хөх эрхэх) 3.эмнэг морь мал уяандаа

эрхэх

Эрэхээ эрхий; хүний гар хөлийн хамгийн том хуруу

Эрэхээвч эрхийвч; хүний эрхий хуруунд өмсгөн хэрэглэх юмны нэр

Эрхлөөлэх эрхлүүлэх; 1.ямар нэгэн ажлыг бие бие даан эрхлэн гүйцэтгэхийн үйлдүүлэх хэв 2.хүүхэд багачууд хайртай хүмүүстээ эрхлэх үйлийн үйлдүүлэх хэв

Эршөөд эршүүд; эмэгтэй хүн эрэгтэй хүн шиг зан байдал, хүч чадал гаргах

Эрэстраан ресторан; зоогийн газар

Эс хэллөөв би хэлсэн биз дээ

Эсгөөр эсгүүр; оёхоор хайчилж бэлдсэн зүйл

Эсгөөлэх эсгүүлэх; эсгэхийн үйлдүүлэх хэв

Эсэргөө эсэргүү; олон хүний санаа үйлээс гажуу буруу

Эсэргөөцэх эсэргүүцэх; эсрэг тэмцэх

Эсэргөөцэл эсэргүүцэл; эсэргүүцэх хүчин чадал

Этөөр этүүр; өлгөх хамах юм

Эхлөөлэх эхлүүлэх; ажил үйлийг эхлэхийн үйлдүүлэх хэв

Эхөөн эхүүн; эхүүн үнэр

Эхээрээ ерөөсөө

Ээвэрдөө ээвэрдүү; ээвэр нөмөр бүхий

Ээдөөлэх ээдүүлэх; сүү зэрэг зүйл язмагтан шар устаж хувирах

Ээзгээ ээзгий; сүүг ээдүүлж буцалган ширгээж, нар салхинд тавьж хатаасан нэгэн зүйл идээний нэр

Ээлгэр жаахан мангардуу, ухаан муутай, элэнгэр юм шиг

Ээлжлөөлэх ээлжлүүлэх; үйл ажиллагаа тогтоосон ээлж дараагаар ажиллахын үйлдүүлэх хэв

Ээрөө ээрүү; үг хэлэхдээ ээрч түгдэрдэг хүн

Ээрөөл ээрүүл; утас томох хэрэгсэл

Ю

Юөлөөр юүлүүр; юмыг юүлж нэг рүү хийхэд хэрэглэх хэрэгсэл

Юөлэх адууг аргамжсан газраас нь шинэ өвстэй газарт сэлгэх

Юөрэх юүрэх; яйрах, мөс юүрэх

Я

Яаравчлоолах яаравчлуулах; аливаа үйл ажлыг

Яароолах яаруулах; аливаа үйл ажлыг хийхдээ шамдан чармайхын үйлдүүлэх хэв

Явоолах явуулах; явах үйлийн үйлдүүлэх хэв

Ягих үглэх, янших

Яйжгар тухайн зүйл байх хэмжээнээсээ хазайсан

Яйя ямар аймаар юм бэ гэсэн утгатай бүтэц бус өгүүлбэр

Ялаах үмхийрэх; унгах

Ялархоо яльгүй өвдөхөд нь их өвдөж байгаа дүр үзүүлэх, тэвчээр муутай

Ялбарах үнэр орсон

Ялз шалз буцлах

Ямаажоолах ямаажуулах; олон ямаатай болохын үйлдүүлэх хэв

Ямаархоо ямаархуу; ямаатай төстэй

Ямбоо ямбуу; хөвөн нэхмэл бүдүүлэг даавуу барааны нэр

Янгооч янгууч;өвдөх зэрэгт тунирхаж элдэв заль авир гаргах

Янгиа хэрэглэл муутай, мод шахуу эмээл

Яндаа хэмжээ; шингэн ба үүрмэг юмыг хэмжих сав

Яндан зуух; дотор нь гал түлэхэд зориулан хийсэн хэрэгсэл

Янжөөр янжуур; цаасанд хуйлсан нэгэн зүйл тамхи

Ярилцоолах ярилцуулах

Ясархоо ясархуу; ясархаг

Ясжоолах ясжуулах; ясжихын үйлдүүлэх хэв

Ятгоолах ятгуулах; бусдад юмны учир чанар, хор холбогдлыг ухуулахын үйлдүүлэх хэв

Ятоо ятуу; гургуултай адил боловч бие жижиг, сүүл охор нэгэн зүйлийн шувуу

Дархад аман аялгууг зарим аман аялгуутай харьцуулсан нь

Дархад, хотгойдын аман аялгууны адил, төстэй шинжээс. Дархадууд XIII-XYIII зууны эхэн үе хүртэл ойрд, хотгойдын захиргаанд байсан бөгөөд одоо хүртэл Хөвсгөл аймгийн хотгойдуудын нутаг болох Арбулаг сумтай хил залгаа оршдог. Түүхийн энэ нөхцөл байдал нь тэдний хэл яриандаа ихээхэн

нөлөөлсөн нь мэдээж хэрэг.

Хотгойд аман аялгууны нарийвчилсан судалгаа 1950-иад оноос хойш хийгдэж эхэлсэн ба 1960 оны зун Зөвлөлтийн эрдэмтэн А.А.Дарбеева оролцсон нутгийн аялгуу, аман зохиол судлах шинжилгээний анги Архангай, Хөвсгөл аймагт хоёр сар гаруй ажиллаж, халхын аман аялгуу, мөн Хөвсгөлийн нутагт халх нарын дунд холилдон суусан хотгойдын аман аялгууны онцлогийг тус тус ажиглаж Ж.Цолоо "Хотгойд аялгууны онцлогоос" гэсэн өгүүллэл бичжээ. Энэ анги нь Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр, Төмөрбулаг, Бүрэнтогтох, Цагаан –Уул, Цэцэрлэг, Бүрэнхаан сумын хотгойд нарын дунд судалгаа хийжээ. 1967 онд Э.Вандуй ахлагчтай эрдэм шинжилгээний анги хотгойд аман аялгууны талаар нэлээд хэрэглэгдэхүүн цуглуулжээ. Үүнээс хойш хотгойд аман аялгууны судалгаа нэлээд хийгджээ. С.Мөөмөө, Ю.Мөнх-Амгалан нар "Орчин үеийн монгол хэл аялгуу" (УБ.,1982) номдоо хотгойд аман аялгууны талаар нэлээд дэлгэрэнгүй бичжээ.

Бид энд хотгойд, дархад аман аялгууны адил, төстэй зүйлийн талаар товч дурдахыг зорилоо.

1. Хотгойдын аман аялгуунд харьяалахын тийн ялгалын "-ы" нөхцөлийг урагшилсан урт а-гаар ā хэлдэг бол дархад аман аялгуунд бүр урагшлуулж урт ā̃ (ээ)-гээр хэлдэг нь төстэй байна. Тухайлбал:

Ут.з.х. тогооны таг- Хот. toγānā-Дарх. Тогаанээ таг
Ут.з.х. зуухны хоолой- Хот. dzūxnā xōlā-Дарх. Зоохнээ хоолээ

2. "ай" хос нь хотгойд аман аялгуунд "аа" авиа болсон бол дархад аман аялгуунд ихэд урагшилж "ээ" болсон нь төстэй байна. Тухайлбал:

Ут.з.х. зуузай- Хот. Зуузаа-Дарх. зоозээ
Ут.з.х. малгай-Хот. малгаа-Дарх. малгээ
Ут.з.х. шагай- Хот. шагаа-Дарх. шагээ

3. Төв халхын аялгууны үгийн I үеийн урт эгшиг "ий" авиа хотгойд, дархадын аман аялгуунд урт эгшиг "аа" болсон нь адилхан байна.

Тухайлбал:

Ут.з.х. шийр- Хот. шаар-Дарх. шаар
Ут.з.х. чийрэг-Хот. чааараг-Дарх. чааараг

4. Бичиг зохиолын хэлний үгийн I ба II үеийн хос эгшиг "уй, үй" авиа нь үгийн аль ч үедээ хотгойд аман аялгуунд "уу, үү" болсон бол дархад аман аялгууны онцлогийн дагуу урт "о" эгшиг болсон нь адил байна.

Ут.з.х. ханцуй-Хот. хамцуу-Дарх. хамцоо
Ут.з.х. үймүүлэх-Хот. үүмүүлэх-Дарх. үүмөөлэх
Ут.з.х. үйл-Хот. үүл-Дарх. үүл

5. Орчин цагийн бичиг зохиолын хэлний үгийн эхний эгшиг "э" авиа нь хотгойд, дархадын аман аялгуунд "и"-гээр ондоошсон нь адил байна. Тухайлбал:

Ут.з.х.эмжээр- Хот.имжаар- Дарх. имжээр

6. "И"- эгшиг авиаг "ү"-гээр дууддаг нь хотгойд, дархадын аман аялгуунд адил байна. Тухайлбал:

Ут.з.х.битүү- Хот.бүтүү-Дарх. бүтөө

7. Эгшиг авиа "а" нь хотгойд, дархадын аман аялгуунд "о,у"-гаар дуудагдаж байгаа нь адил байна. Тухайлбал:

Ут.з.х.чухам- Хот.цохом- Дарх.цохом

8. Гийгүүлэгч авиа "ч" нь хотгойд, дархадын аман аялгуунд "м"-ээр ондоошин дуудагддаг нь адил байна. Тухайлбал:

Ут.з.х. ханцуй- Хот. хамцуу- Дарх. хамцоо
Ут.з.х. унших- Хот. умших-Дарх. умших

9. Гийгүүлэгч "в" нь хотгойд, дархадын аман аялгуунд "г"-ээр ондоошсон нь адил байна. Тухайлбал:

Ут.з.х. дэвтэр- Хот. дэгтэр- Дарх. дэгтэр

10. Гийгүүлэгч авиа "д" нь "з"-гээр ондоошин дуудагдах нь хотгойд, дархадын аман аялгуунд адил байна. Тухайлбал:

Ут.з.х. гадаа- Хот. газаа-Дарх. газаа

11. Гийгүүлэгч авиа "р,л,м,г,ш" нь хоорондоо байр сольж тонгордог нь хотгойд, дархадын аман аялгуунд адил байна. Тухайлбал:

Ут.з.х. догшин-Хот. дошгин-Дарх. дошгин
Ут.з.х. хярам-Хот. хямар-Дарх. хямар
Ут.з.х. алчуур-Хот. арчуул- Дарх. арчуул

12. Бичиг зохиолын хэлний үгэнд байхгүй авиаг нэмж оруулан хэлдэг үзэгдэл заримдаа тохиолдож байгаа нь хотгойд, дархадын аман аялгуунд адил байна. Тухайлбал:

Ут.з.х. атгаал-Хот. атгамал-Дарх. атгамал
Ут.з.х. өчигдөр-Хот. өцгөлдөр-Дарх. өцгөлдээр

13. Хотгойдын аман аялгууны үгсийн сан нь бичиг зохиолын хэлний үгсийн сангаас үлэмжхэн ялгаатай үгс байгаа нь дархадын аман аялгуунд адил байна.Тухайлбал:

Ут.з.х.	Хот.	Дарх.
Ааруулын мод	андар	андар
Эрэх, хайх	бэдрэх	бэдрэх

Бөгж	билзэгэ	билзэгэ
Боолт, уяа	боодог	боодаг
Нөмгөн	сэлдэн	сэлдэн
Тогооны таг	халив	халим
Нөмрөх	көдрөх	хөдрөх
Өлгүүр	цах	цах
өлгий, манцуй	манцуу	манцоо
тагнай	танглай	танглээ гэх мэт.

Дархад, буриад аман аялгууны адил, төстэй шинжээс.

Буриад аялгуунд:

1. Үйл үг нь гурван биеийг зааж хувилж байгаа нь дархад аман аялгуутай төстэй байна.
2. Биеэр төгсгөх үйл үгийн хүндэтгэн захирахын "-гтий" хэлбэр байгаа нь дархад аман аялгууны "-гтээ"хэлбэртэй утга дүйнэ. бур. Та орогтий-дарх.Та орогтээ –Ут.з.х-Та орогтун.
3. Барга буриад аман аялгуунд олон тооны дагаврыг давхар хэрэглэдэг нь ижил байна. Бид нэр-дарх. бид нэр- Ут.з.х. бид
4. "га"-г "ха"-гаар дууддаг нь ижил байна. Батхан-дарх. батхан-Ут.з.х. батгана
5. Сартуул буриадын аман аялгуунд Дэвскэр-дарх. дэвсгэр- Ут.з.х. дэвсгэр Мэлхээ-дарх. мэлхээ-Ут.з.х. мэлхий зэрэг үг ижил байгааг судлаачид тэмдэглэсэн байна.

Дархад, ойрд аман аялгууны адил, төстэй шинжээс.

Ойрд аялгуунд:

1. Үйл үг нь гурван биеийг зааж хувилж байгаа нь дархад аман аялгуутай төстэй байна. Жишээ нь: Би ирнэв-дарх. Би ирнэв-Ут.з.х. Би ирнэ.
2. Биеийн төлөөний үгийн маанар гэсэн хэлбэртэй байгаа ижил байна. Жишээ нь:Ойрд. маанар-дарх. маанар-Ут.з.х. бид
3. Үгийн нэгдүгээр үеэс хойш урт эгшиг оо-гийн байранд аа, өө-гийн байранд ээ үүссэн нь ижил байна
4. Баяд аман аялгуунд зарим үгийн у-г о-гоор дуудаж байгаа нь ижил байна. Жишээ нь: дуун-доон
5. Захчин аман аялгуунд жуу (чи яв жуу)хэлбэр байгаа нь дархад аман аялгууны "жоо" гэсэн хэлбэртэй утга дүйнэ. Жишээ нь: Чи яв жуу- дарх. Чи яв жоо-Ут.з.х. Чи яв.
6. Захчин аман аялгуунд аялгуунд биеэр төгсгөхийн -ийт, -ийч нөхцөл байгаа нь дархад аман аялгууны "-аат,-ээт, -аач,-ээч" гэсэн хэлбэртэй утга дүйнэ. Жишээ нь: Та явийт- дарх. Та яваат-Ут.з.х. Та яв.

7. Үгсийн сангийн хувьд адил төстэй дараах үгс байгааг судлаачид тэмдэглэжээ.

Зах.газаа- дарх.газаа-Ут.з.х.гадаа
Зах. оошиг-дарх. оошиг- Ут.з.х.уушиг
Зах,Өөлд,Дөр. урал- дарх.урал-Ут.з.х.уруул
Зах. гүрк-дарх.гүрэх- Ут.з.х.сүлжих
Зах. химир-дарх. хямар- Ут.з.х.хярам
Зах. көдрөх -дарх. хөдрөх- Ут.з.х.нөмрөх
Урианхай. өрөөл- дарх.өрээл- Ут.з.х.ерөөл
Өөлд. көндээ-дарх.хөндээ-х Ут.з.х.хөндий
Өөлд. солгаа-дарх.солгээ- Ут.з.х.солгой
Өөлд. бичкэн-дарх. бичгэн- Ут.з.х.бяцхан
Өөлд. өцгөлэдөр-дарх.өцгөлдээр- Ут.з.х.өчигдөр
Өөлд. батхан-дарх.батхан- Ут.з.х.батгана
Өөлд. оргомч-дарх.оргомч- Ут.з.х.уулгамч
Өөлд. сампин-дарх.сампин- Ут.з.х.зангадаж уясан товч
Өөлд. ташир-дарх. ташир- Ут.з.х.давхар
Өөлд. манз-дарх. манз- Ут.з.х.дээлийн энгэрийн хэсэг
Өөлд. бичгэн-дарх.бичгэн- Ут.з.х.бяцхан
Өөлд.цах-дарх.цах- Ут.з.х.өлгүүр мод

Товчилсон үгийн тайлбар:

Дарх.-дархадын аман аялгуу
Хот.-хотгойдын аман аялгуу
Халх.-халхын аман аялгуу
Ут.з.х.-утга зохиолын хэл
Өөлд.-Өөлд аман аялгуу
Зах.-Захчин аман аялгуу

Ашигласан ном

1. Г.Баасанжав, О.Пүрэв "Хөвсгөл аймгийн хөг аргиг " УБ.,1983
2. Д.Батжаргал "Дархад ардын дууны яруу найраг" "Маанар" сонин 2004
3. Ц. Баттөмөр "Нутаг амьтай сэтгэл" Мөрөн., 2001
4. Ж.Гун-Аасүрэн "Дархад дууны төрөл зүйл, уран сайхны онцлог" УБ., 2004
5. Ц.Дамдинсүрэн, Б.Осор "Монгол үсгийн дүрмийн толь" УБ.,1983
6. Ш.Лувсанвандан "Орчин цагийн монгол хэлний урт эгшгийн гарлын тухай асуудалд" Хэл зохиол 1967.4
7. С.Мөөмөө Ю.Мөнх-Амгалан "Орчин үеийн монгол хэл аялгуу" УБ.,1982
8. О.Пүрэв"Монгол бөөгийн шашин" УБ.,2006
9. Д.Пүрэвдорж "Дархадын нэртэй буюу домогт дуунууд" УБ., 1998
10. Б.Ринчин "Монгол бөөгийн шашин" УБ.,2006
11. Ж.Санжаа, Д.Туяа "Дархад аман аялгууны урт эгшгийн онцлог" УБИС-ийн эрдэм шинжилгээний өгүүлэл УБ.,2002
12. Г.Д.Санжеев "Дархатский говор и фольклор" Л.,1931
13. Д.Төмөртогоо "Дархад аман аялгууны урт эгшиг, тэдгээрийн үүслийн тухай товч тэмдэглэл" Хэл зохиол IY боть. УБ.,1967 хуудас 196-204
14. Д.Төмөртогоо "Дунд үеийн монгол хэлний эгшиг авианы ижилшил" Монгол судлал 1967.8
15. Д.Төмөртогоо "Монгол хэлний түүхэн хэлзүй" УБ., 1992
16. Ж.Төмөрцэрэн "Баргын тухай товч тэмдэглэл" Монгол судлал 1971.8
17. Л.Хүрэлбаатар "Дуун утгын яруу зохист" УБ., 2005
18. Ж.Цолоо "Хотгойд аман аялгууны зарим онцлогоос" ШУА-ийн мэдээ УБ., 1962.№4
19. Ж.Цолоо "Урианхай аялгууг судалсан зарим дүн" Хэл зохиол 1972.9
20. Я.Цэвэл "Монгол бичгийн товч тайлбар толь" УБ.,1966
21. Д.Цэнд "Монгол хэлний нутгийн аялгууны судлалын тойм" УБ.,1959

7. Үгсийн сангийн хувьд адил төстэй дараах үгс байгааг судлаачид тэмдэглэжээ.

Зах.газаа- дарх.газаа-Ут.з.х.гадаа
Зах. оошиг-дарх. оошиг- Ут.з.х.уушиг
Зах,Өөлд,Дөр. урал- дарх.урал-Ут.з.х.уруул
Зах. гүрк-дарх.гүрэх- Ут.з.х.сүлжих
Зах. химир-дарх. хямар- Ут.з.х.хярам
Зах. көдрөх -дарх. хөдрөх- Ут.з.х.нөмрөх
Урианхай. өрөөл- дарх.өрээл- Ут.з.х.ерөөл
Өөлд. көндээ-дарх.хөндээ-х Ут.з.х.хөндий
Өөлд. солгаа-дарх.солгээ- Ут.з.х.солгой
Өөлд. бичкэн-дарх. бичгэн- Ут.з.х.бяцхан
Өөлд. өцгөлэдөр-дарх.өцгөлдээр- Ут.з.х.өчигдөр
Өөлд. батхан-дарх.батхан- Ут.з.х.батгана
Өөлд. оргомч-дарх.оргомч- Ут.з.х.уулгамч
Өөлд. сампин-дарх.сампин- Ут.з.х.зангадаж уясан товч
Өөлд. ташир-дарх. ташир- Ут.з.х.давхар
Өөлд. манз-дарх. манз- Ут.з.х.дээлийн энгэрийн хэсэг
Өөлд. бичгэн-дарх.бичгэн- Ут.з.х.бяцхан
Өөлд.цах-дарх.цах- Ут.з.х.өлгүүр мод

Товчилсон үгийн тайлбар:

Дарх.-дархадын аман аялгуу
Хот.-хотгойдын аман аялгуу
Халх.-халхын аман аялгуу
Ут.з.х.-утга зохиолын хэл
Өөлд.-Өөлд аман аялгуу
Зах.-Захчин аман аялгуу

Ашигласан ном

1. Г.Баасанжав, О.Пүрэв "Хөвсгөл аэжийн хөг эгшиг " УБ.,1983
2. Д.Батжаргал "Дархад ардын дууны яруу найраг" "Маанар" сонин 2004
3. Ц. Баттөмөр "Нутаг амьтай сэтгэл" Мөрөн., 2001
4. Ж.Гун-Аасүрэн "Дархад дууны төрөл зүйл, уран сайхны онцлог" УБ., 2004
5. Ц.Дамдинсүрэн, Б.Осор "Монгол үсгийн дүрмийн толь" УБ.,1983
6. Ш.Лувсанвандан "Орчин цагийн монгол хэлний урт эгшгийн гарлын тухай асуудалд" Хэл зохиол 1967.4
7. С.Мөөмөө Ю.Мөнх-Амгалан "Орчин үеийн монгол хэл аялгуу" УБ.,1982
8. О.Пүрэв"Монгол бөөгийн шашин" УБ.,2006
9. Д.Пүрэвдорж "Дархадын нэртэй буюу домогт дуунууд" УБ., 1998
10. Б.Ринчин "Монгол бөөгийн шашин" УБ.,2006
11. Ж.Санжаа, Д.Туяа "Дархад аман аялгууны урт эгшгийн онцлог" УБИС-ийн эрдэм шинжилгээний өгүүлэл УБ.,2002
12. Г.Д.Санжеев "Дархатский говор и фольклор" Л.,1931
13. Д.Төмөртогоо "Дархад аман аялгууны урт эгшиг, тэдгээрийн үүслийн тухай товч тэмдэглэл" Хэл зохиол IY боть. УБ.,1967 хуудас 196-204
14. Д.Төмөртогоо "Дунд үеийн монгол хэлний эгшиг авианы ижилшил" Монгол судлал 1967.8
15. Д.Төмөртогоо "Монгол хэлний түүхэн хэлзүй" УБ., 1992
16. Ж.Төмөрцэрэн "Баргын тухай товч тэмдэглэл" Монгол судлал 1971.8
17. Л.Хүрэлбаатар "Дуун утгын яруу зохист" УБ., 2005
18. Ж.Цолоо "Хотгойд аман аялгууны зарим онцлогоос" ШУА-ийн мэдээ УБ., 1962.№4
19. Ж.Цолоо "Урианхай аялгууг судалсан зарим дүн" Хэл зохиол 1972.9
20. Я.Цэвэл "Монгол бичгийн товч тайлбар толь" УБ.,1966
21. Д.Цэнд "Монгол хэлний нутгийн аялгууны судлалын тойм" УБ.,1959